Салхитын мөнгө-алтны уурхайн биологийн нөхөн сэргээлтийг эхлүүлсэн бөгөөд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан тоо хэмжээний дагуу биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

- Алтан харганын үр – Дорноговь аймгийн нутгаас бэлтгэсэн.
- Коржинскийн харганын үр - Дорноговь аймгийн Алашаа говийн цөлөөс бэлтгэсэн.
- Үхэр харганын үр – Говьсүмбэр аймгийн нутгаас бэлтгэсэн.
- Нарийн навчит харганын үр – Говьсүмбэр аймгийн нутгаас бэлтгэсэн.
- Бунгын харганын үр – Их нууруудын хотгороос бэлтгэсэн үрээр тарьсан.

Цөлөрхөг хээрийн буюу говийн бүс нутагт элбэг ургадаг 5 зүйл харганын үрийг шуудуугаар үр хооронд 23 см зайтай өргөн мөрөөр, 2-5 см-ийн гүнд 2 хүлэмжинд тариалсан.

Уурхайн хаягдал чулуулгийн овоолгын налууд хөрс тогтворжуулах геосетка байрлуулж шинэ технологи туршиж олон наст зүлэг тарьсан. ХААИС-ийн харьяа МАА Бэлчээрийн хүрээлэнгийн генийн сангаас Сүмбэр сортын Саман ерхөг, Мандал сортын Эмзэг түрүүт өлөн, Бургалтай сортын шар царгасын үрээр ургамалжуулах ажлыг 0,5 га талбайд тарьсан. Овоолго 1-ийн налуу дээр 0.5 га талбайд ургамалжуулсан.

Салхитын мөнгө-алтын ордыг ил аргаар ашиглах төслийн Хаалтын менежментийн төлөвлөгөөний дагуу 2025-аас хойш жилүүдэд биологийн нөхөн сэргээлт хийх газруудыг тодорхойлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Энэхүү туршлага нь манай компани-д уурхайн талбайд хаалтад чиглэсэн явцын нөхөн сэргээлтийг ашиглалтын үе шатанд хийх боломжтойг орон нутаг, төрийн бүх шатны байгууллагад нотлон харуулахаас гадна дараах хоёр үндсэн ач холбогдолтой. Үүнд:

1. Нөхөн сэргээлтийн шилдэг техник, технологийг турших, үнэлэх боломжийг олгох
2. Явцын нөхөн сэргээлт хийгдсэн талбайн нөхөн сэргээлтийн амжилттай арга техникийг оролцогч талуудад таниулах, уул уурхайн салбар дахь шилдэг практикийг цаашид дэлгэрүүлэх.

“Эрдэнэс алт ресурс” ХХК 2022-2023 онуудад Байгаль орчны тухайн жилийн менежментийн төлөвлөгөөнд төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэж ажлын гүйцэтгэлийг актаар орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад хүлээлгэн өгсөн. 2025 онд төлөвлөгдсөн нөхөн сэргээлтийн ажлаас хаягдлын овоолгыг налуужуулах техникийн нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлэх бөгөөд цаашид биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.



**ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ, НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Тэрбум мод тарих” аяны хүрээнд Хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл” талбайд 30000 ширхэг хайлаас, мод тарина.	Уурхайн талбайд Уурхайд хуучин таригдсан мод бүхий талбайд нөхөн тарилт хийх, шинээр мод тарьсан байна.	75'555	183'887'500 + 248,812,500	Үндсэн болон нийт туслан гүйцэтгэгч компаниудын идэвхи оролцоо, дэмжлэгтэйгээр хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдийн хүрээнд мод тарих ажлыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хийж хэрэгжүүлнэ.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 50000 ширхэг хайлаас мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд нийт 2000 ширхэг 3-5 настай шинэс модны суулгацыг тарих ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа. “Эрдэнэс

					<p>алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 20000 ширхэг хайлаас модны суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд 20000 ширхэг модыг Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д нэмэлтээр тарилаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 75555 модыг тарьсан.</p> <p>“Тэрбум мод” санаачилгын хүрээнд Богдхан уулын дархан цаазат газарт мод тарих ажлын гэрээг “Эрдэнэс алт ресурс” ХХК Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж, тус гэрээг БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ баталгаажуулсан.</p>
--	--	--	--	--	---

						Уг гэрээний хүрээнд “Эрдэнэс алт ресурс” ХХК Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд 5000 мод тарьж арчилж ургуулна.
2	Алтан Солин ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2024 оны 4 сараас 125,000 ширхэг 2 настай улиас хайлаас модны суулгацыг хүлээн авч хашаа болон усалгаа арчилгааг шийдэн төгөл байгуулах	Өмнөх онуудад бойжуулсан суулгацыг хүлээн авч, тарих газруудыг Ойн газартай болон төсөл хэрэгжиж буй орон нутгийн захиргаатай харилцан тохиролцож шийдвэрлэсэн байна.	73555	-	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллана.	Алтан солин ХХК-иас 2024 онд нийт 73555 ширхэг суулгацыг авч 2024 оны Хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдээр тарилт хийж гүйцэтгэсэн.
3	Хэнтий аймгийн Батширээт суманд мод үржүүлгийн талбайг байгуулсныг Дундговь	Дундговь аймагт мод үржүүлгийн талбайг шинээр байгуулах, шаардалагатай тоног	-	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт, Салхит уурхайг болон бусад худаг ус, цахилгааны асуудал шийдвэрлэгдэх	Хэнтий аймгийн Батширээт суманд байгуулахаар төлөвлөж байсан мод үржүүлгийн газрын техник хэрэгсэл, модны усалгаа, арчилгааны хэрэгслийг Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь Салхит уурхайд зөөвөрлөж авчирсан. Цаашид мод үржүүлэг

	аймаг руу шилжүүлэн байгуулах	төхөөрөмж, ажиллах хүч, бусад дэд бүтцийн асуудлыг бүрэн төлөвлөж, бэлэн байдлыг хангасан байна			боломжтой газрыг түшиглэн байгуулна.	байгуулахад ашиглана.
4	Мод үржүүлгийн 5 га талбайг хашаажуулж, гүний худаг гаргах, Өмнөх онуудад бойжуулсан суулгацыг тарих, хүлэмж барих	Мод тарьж ургуулахад шаардлагатай усны эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.	7 га	19'300'000	Компанийн эзэмшлийн хүлэмжнүүдэд модны суулгац тарьж	Салхит уурхайд байгуулсан Эрдэнэс төгөл-ийг өргөтгөж, мод тарих талбайн газрын зөвшөөрлийг авч хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн мод услах зориулалттай худгийг бусад үйл ажиллагаанд ашиглахгүй байдлаар тусгаарласан .
НИЙТ ДҮН				452'000'000		



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 50000 ширхэг хайлаас мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд нийт 2000 ширхэг 3-5 настай шинэс модны суулгацыг тарих ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа. “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 20000 ширхэг хайлаас модны суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд 20000 ширхэг модыг Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д нэмэлтээр тарилаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 75555 модыг тарьсан.

“Тэрбум мод” санаачилгын хүрээнд Богдхан уулын дархан цаазат газарт мод тарих ажлын гэрээг “Эрдэнэс алт ресурс” ХХК Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж, тус гэрээг БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ баталгаажуулсан. Уг гэрээний хүрээнд “Эрдэнэс алт ресурс” ХХК Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд 5000 мод тарьж арчилж ургуулна.



Богдхан уулын Чандманы аманд тарьсан модыг хамгаалах зорилгоор 4.8 га талбайг тойрсон хамгаалалтын хашаа барих ажлыг "Хүчит дөрвөн арслан" ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлийг дүгнэж, актаар хүлээн авсан. Уг ажлыг 14'800'000 төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Богд ууланд мод тарьсан аж ахуйн нэгжүүдийн мод тарилт, хашаа хамгаалалт, арчилгаа усалгааны байдлыг газар дээр нь шалгахад хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг танилцуулж ажилласан.

БҮЛЭГ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт Тарвага сэргээн нутагшуулах ажлыг хамгаалалтын захиргаатай хамтран зохион байгуулах	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	50 тарвага	32'000'00	Тарвага сэргээн нутагшуулсан байна.	Их газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран Хустайн байгалийн цогцолборт газраас зэрлэг амьтдын нөөцийн хомсдлыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор тарвага нутагшуулах ажлыг тус онд төлөвлөн ажилласан.
2	Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах ажлын хүрээнд биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	200 боодол	4'000'000	Судалгаа, биотехникийн арга хэмжээг авч ажилласан байна.	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсан Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт нутагшдаг зэрлэг амьтдыг /аргаль, янгир/ идэш тэжээлийн хомсдолоос сэргийлэх ажлын хүрээнд биотехникийн арга хэмжээнд зориулан 200 боодол өвсийг 2024

						оны 12 дугаар сарын 10-ны өдөр Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн.
3	Туруутан амьтны тоо толгойг тогтоох нүүдэл шилжилтийг тодорхойлох, амьтдын тоо толгойн мониторинг явуулах, ажиглалтын зурвас замналын судалгааны ажлыг газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах Их	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	1 удаа	500'000	Туруутан амьтны тооллого судалгааг хамтран зохион байгуулсан байна.	Уулын туруутан амьтдын намрын тооллого судалгааг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны албан хаагчидтай хамтран хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнгээр янгир ямаа нь Их газрын чулууны уул, аргаль хонь нь Ерлөг ууланд арай олон тоогоор ажиглагдсан. Сүргийн бүтцийн ашиглалт нь аргаль, янгирын сүргийн бүтцийн эм бодгалийн тоо, залуу бодгалийн тоо их байгаа нь цаашид өсөх хандлагатай байна. Мөн компаний веб сайтаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан.

4	Өмнөх онуудад сэргээн нутагшуулсан тарвагануудыг ажиглалт судалгаагаар баталгаажуулах	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	1 удаа	500'000	Судалгааг хамтран хийсэн байна.	<p>2019, 2021, 2022, 2024 онуудад нутагшуулсан тарвагануудад ажиглалт судалгааг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагч нартай хамтран 2 удаа хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн тайлангаар Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын Өлзийт, Дөрвөлжин, Үзүүр хад, Хайрхан баруун тал, Адгийн бунханта, Шар малгайт, Сүвт хонд, Шавгын улаан зэрэг газруудад тарвага нутагладаг.</p> <p>Тарваганы ажиглалт судалгаагаар бие гүйцсэн 131 бодгаль, хотил 8 бодгаль, мөндөл 14 бодгаль, тодорхойгүй 9 бодгаль нийт 162 бодгаль нутаглаж байгааг тогтоож зурагжуулсан байна.</p> <p>Мөн ажиглалтын камер</p>
---	---	---	--------	---------	---------------------------------	---

						байршуулж ажилласан.	зурагжуулж
5	Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт шаардлагатай 2 байршилд хөв цөөрөм байгуулах	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	2 ширхэг	24'800'000	Зэрлэг амьтад ундаалах ил задгай уст цэг нэмэгдэж, идэш тэжээл авах таатай орчин бүрдэнэ. Тус ажлыг Их газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлнэ.	Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт шаардлагатай 2 байршилд 2 ширхэг хөв цөөрөм байгуулсан. Уг ажлыг тендер зарлаж гүйцэтгүүлсэн бөгөөд "Роуд Дэвэллопмент" ХХК нь "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн 2024 оны байгаль орчны дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Их газрын чулууны уул, Ерлөг уул Хөв цөөрөм барих ажлыг 2024 оны 08 дугаар сарын 13-наас 2024 оны 08 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.	
6	"Нөхөн сэргээлт-2024" арга хэмжээний хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын эвдэрч, эзэнгүй орхигдсон	Дундговь аймгийн Дэлгэрцогт сум	4,33 га	70'000'000	Орон нутгийн ажлын хэсгээс 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй тусгах ажлуудын саналд тусгагдсаны дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон, нөхөн сэргээлт хийгдэх шаардлагатай газруудын нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилготойгоор орон даяар "Нөхөн сэргээлт-2024" арга	

	<p>талбайн 2.3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх</p>				<p>гүйцэтгэнэ.</p>	<p>хэмжээг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж буй ажлын хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хүлээж авах ажлын хэсгийн зүгээс Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Буурал, Төмөрт, Ар цагаан гэх газруудад өнгөт чулуу хууль бус олборлолтоос эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-д даалгасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд нийт 11 байршилд хамаарах 4,33 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн орон нутагт актаар хүлээлгэн өгсөн. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явцад Дундговь аймгийн Байгаль орчны газар, Дэлгэрцогт сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Дундговь аймгийн Байгаль орчны газрын</p>
--	--	--	--	--	--------------------	--

						мэргэжилтэн, Дэлгэрцогт сумын байгаль орчны мэргэжилтэн, Цахиурт багийн Засаг дарга, Дэлгэрцогт сумын нутгийн иргэд ажлын үе шат бүр хамтарч хяналт тавин ажилласан.
НИЙТ ДҮН				131'800'000		

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛЛЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

Цөлжилт, хүний буруутай үйл ажиллагаанаас Дундговь нутагт өмнө нь олноор байсан тарвага ховордож устгах аюулд өртсөн байна. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр 50 ширхэг, 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 50 ширхэг буюу нийт 100 ширхэг тарвагыг Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт амжилттай нутагшууллаа.

“Эрдэнэс алт ресурс” ХХК, Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Их газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран Хустайн байгалийн цогцолборт газраас зэрлэг амьтдын нөөцийн хомсдлыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах зорилгоор 2 удаагийн зөөвөрлөлтөөр нийт 100 ширхэг тарвагыг зөөвөрлөн авчирч нутагшуулсан.

Уг ажил нь ан амьтдын орчныг хамгаалах, нөхөн үржихэд чиглэсэн ажил бөгөөд орон нутгийн байгууллагуудтай зөвшилцөн, уялдан ажиллаж үр дүнд хүрч буй хариуцлагатай уул уурхайн сайн жишээ болж байна.





Уулын туруутан амьтдын намрын тооллого судалгааг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны албан хаагчидтай хамтран хийж гүйцэтгэсэн. Уг судалгаагаар нийт аргаль хонь, янгир ямаа нийлээд 200 гаруй бодгаль бүртгэгдсэн. Судалгааны үр дүнгээр янгир ямаа нь Их газрын чулууны уул, аргаль хонь нь Ерлөг ууланд арай олон тоогоор ажиглагдсан. Сүргийн бүтцийн ашиглалт нь аргаль, янгирын сүргийн бүтцийн эм бодгалийн тоо, залуу бодгалийн тоо их байгаа нь цаашид өсөх хандлагатай байна. Мөн компаний веб сайтаар олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулж ажилласан.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсан Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт нутагшдаг зэрлэг амьтдыг /аргаль, янгир/ идэш тэжээлийн хомсдолоос сэргийлэх ажлын хүрээнд биотехникийн арга хэмжээнд зориулан 200 боодол өвсийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн.



Хөв цөөрөм байгуулах ажил

- Хөв цөөрөм барих ажлыг нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй 2024 оны 08 дугаар сарын 13-наас 2024 оны 08 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэсэн.
- 2 хөв цөөрөм барих газрыг Их газрын чулууны БЦГ-ын Их газрын чулууны уул, Ерлөг ууланд тус бүр 1 ширхэгийг барьсан.
Өргөн 5 метр, урт нь 7 метр, гүн 40-50 см, газрын гадаргаас дээш 10 см цутгаж байгалийн чулууг зөөн тээвэрлэж доторлож чигжиж аль болох байгальд нь зохицохоор хийсэн.



Их газрын чулууны ууланд хийсэн хөв цөөрмийн зураг



2024 оны биотехникийн арга хэмжээний хүрээнд Их газрын байгалийн цогцолборт газарт байрлах хөв цөөрөмд ус хийж зэрлэг амьтад ундаалах нөхцөлийг бүрдүүлсэн.



2024 оны 5 дугаар сард Их газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны албан хаагчидтай хамтран туруутан амьтдын тооллого судалгааг хийж гүйцэтгэсэн.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРТЦОГТ СУМЫН НУТАГТ ХИЙГДСЭН ЭВДЭРСЭН ГАЗАР НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон, нөхөн сэргээлт хийгдэх шаардлагатай газруудын нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилготойгоор орон даяар "Нөхөн сэргээлт-2024" арга хэмжээг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж буй ажлын хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хүлээж авах ажлын хэсгийн зүгээс Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Буурал, Төмөрт, Ар цагаан гэх газруудад өнгөт чулуу хууль бус олборлолтоос эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг "Эрдэнэс алт ресурс" ХХК-д даалгасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд нийт 11 байршилд хамаарах 4,33 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн орон нутагт актаар хүлээлгэн өгсөн.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явцад Дундговь аймгийн Байгаль орчны газар, Дэлгэрцогт сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Дундговь аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн, Дэлгэрцогт сумын байгаль орчны мэргэжилтэн, Цахиурт багийн Засаг дарга, Дэлгэрцогт сумын нутгийн иргэд ажлын үе шат бүр хамтарч хяналт тавин ажилласан.



Зураг. Нөхөн сэргээлт хийхийн өмнө захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын төлөөллүүд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Засаг даргатай уулзаж буй нь



БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус ордын ашиглалтын лицензийн талбайд үйлдвэрлэлийн болон уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах (шилжүүлэх) арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй.

БҮЛЭГ 6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олдохыг үгүйсгүй. Тиймээс уурхайн үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн тохиолдолд сум, аймгийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлт
1	Тусгай зөвшөөрлийн талбайд байх Археологийн байгууламжуудыг хөндөж сүйтгэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах бөгөөд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулна. 2024 онд Салхитын Зүүн эрлийн талбайд хайгуулын ажил хийхээр төлөвлөгдсөн тул тус талбайд хамаарна	Уурхайн орчимд	500 000	Илэрсэн тохиолдолд	Жилийн турш	Уурхайн техник, хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас анхны зохион байгуулалтаа алдаж устаж үгүй болох эрсдлээс тогтмол сэргийлж, хяналт тавин ажилласны хүрээнд тохиолдол гараагүй болно.

2	Хэрэв газар хөндөх шаардлага үүссэн тохиолдолд 2020 онд хийгдсэн Археологийн судалгааны үр дүнд Археологийн байгууламжуудыг хөндөж сүйтэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Уурхайн орчимд		Илэрсэн тохиолдолд	Жилийн турш	Археологийн судалгааны тайлангийн дагуу Археологийн байгууламжуудыг хөндөж сүйтэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Геологи хайгуул, ашиглалт, барилга бүтээн байгуулалт, дэд бүтцийг өргөтгөх шинээр байгуулсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн туслан гүйцэтгэгч компаниудын удирдлага, ажилчдад ажил гүйцэтгэхээр ирэх үед нэгдсэн зааварчилгаа, сануулга зэргийг өгч гарын үсгээр баталгаажуулж ажилласан.
Нийт зарцуулсан төсөв			500'000			

БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 Ил уурхайн	Хаягдлын далангийн ажлыг холбогдох зураг төслийн дагуу хийж гүйцэтгэн орон нутаг болон улсын комист хүлээлгэн өгсөн.

	комисст хүлээлгэн өгөх			аюулгүй ажиллагааны дүрэм	
2	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар		Дундговь аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу хийгдсэн хяналт шалгалтын хүрээнд газардуулгыг шалгасан зөрчил илэрсэн хэсгийг засаж сайжруулах үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын дагуу дутагдал арилгах төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хүргүүлсэн.
3	Барилга байгууламжуудийн зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар		Хаягдлын далангуудыг үерээс хамгаалах үерийн далан, суваг барих ажлыг 8 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд барьж 12 дугаар сард хийж гүйцэтгэсэн. Мөн үерийн усыг нөөцлөх цөөрмийг бас хийсэн.
4	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Гамшгаас хамгаалах тухай хууль	2024 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Дундговь аймгийн Онцгой байдлын газраар батлуулж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны журмуудыг компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилладаг.

5	Гадаргын усны урсацыг өөрчлөх, үерийн далан шуудуу татах, хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Сургалт зохион байгуулсан байна.	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, Гамшгийн төлөвлөгөө, Аюулын үед ажиллах төлөвлөгөө, Компанийн галын аюулгүй байдлын дүрмийн танилцуулгыг Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн, Галын аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүд нийт ээлжээр ажиллаж буй ажилтнуудад давтамжтайгаар сургалт зохион байгуулж ойлголт мэдээллийг өгч ажилласан.
6	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Уурхайн хэмжээнд	500.000	Эрсдэлээс хамгаалсан байна.	Уурхайн ажлуудыг аюулгүй явуулахад шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой журам, зааварчилгаануудыг боловсруулж, ажилтан бүрт танилцуулж, журмын биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хүрээнд компанийн зүгээс нийт ажилчдад хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн ханган ажилласан.
7	Химийн бодисыг зориулалтын агуулахад хадгалах, хамгаалах хэрэгсэл, материалыг зохих газруудад байрлуулах	Баяжуулах үйлдвэр, Химийн бодисын агуулах, Лаборатори, Тэсрэх бодисын	-	Аюултай хог хаягдлуудыг нэг цэгт төвлөрүүлэх, стандартын дагуу хадгалах байрыг	Уурхайн баяжуулах үйлдвэр болон шинжилгээний лабораторийн үйл ажиллагаанд шаардлагатай Химийн бодисын ашиглах, хадгалах зөвшөөрөл авах ажлыг гүйцэтгэн, орон нутгийн хяналтын газраас уурхайн химийн бодисын 2 агуулах дээр “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн

		агуулах		тохижуулах ажилд хяналт тавин ажилласан байна.	хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартын холбогдох шаардлагын дагуу хяналт тавьж ажилласан. Лабораторийн хэрэгцээнд ашиглаж буй зарим химийн бодисын сав баглаа боодлыг тусгай зориулалтын контейнер гарган хадгалсан. “Аглаг хангай уулс” ХХК нь 2024 онд баяжуулах 1 дүгээр үйлдвэрт 6 нэр төрлийн химийн бодис, “Соёолон Интернэшнл” ХХК-ийн баяжуулах 2 дугаар үйлдвэрт 6 нэр төрлийн химийн бодисуудыг технологийн горимын дагуу үйл ажиллагаандаа ашигласан. Тус бодиснуудыг 2 үйлдвэрийн 2 химийн бодисын агуулахад стандартын дагуу ангилан, тэмдэгжүүлж ашигласан. Мөн химийн бодисын агуулахад шат, тавиур, хаягжуулалт, тасалгаа хийж эмх цэгцтэй хураасан.
8	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах бүх арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламжууд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Гамшгаас хамгаалах тухай хууль	Галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрлийг 2024 оны 09 дүгээр сарын 01-нд гаргуулсан. Энэ онд 2024 онд галын аюул, гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх сургалтыг нийт 8 удаа зохион байгуулж ажилласан.

					<p>Шатахуун түгээх станцын байрлал нь уурхайн автозасварын цехийн ойролцоо байрлалд байрладаг бөгөөд галын аюулаас хамгаалах хэрэгслүүдийг шинэчлэн байршуулсан. Гадна зам талбайг тэгшилж стандартын дагуу болгох болон бусад тохижилт сайжруулалт, засварын ажлуудыг тус онд нэмэлтээр хийж гүйцэтгэсэн., Галын аюулгүй байдлыг тусгай зориулалтын хэрэгслийг захиалж бүрдүүлэлт хийсэн. Уг ажлын зардлыг төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж тооцоогүй болно.</p>
			500'000		

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмын дагуу хяналт тавин ажиллах	Уурхайн талбайд	Гэрээний зардлаар	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмын дагуу хяналт тавин ажилласан байна.	Хог хаягдлын журмын дагуу туслан гүйцэтгэгч компаниудад тогтмол хяналт тавьж ажилласан. “Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2024 онд “Түмэн эгшиг” ХХК-тай, шинжилгээний лабораторын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа “Трү ти ар си” ХХК нь “Элемэнт” ХХК-тай, Баяжуулах 1 дүгээр үйлдвэрийг хариуцан ажиллаж байгаа “Аглаг хангайн уулс” ХХК нь “Түмэн эгшиг” ХХК-тай, Баяжуулах 2 дүгээр үйлдвэрийг хариуцан ажиллаж байгаа “Соёолон интернэшнл” ХХК нь “Түмэн эгшиг” ХХК, “Ариун хими” ХХК-тай аюултай хог хаягдал устгах гэрээг байгуулан хууль, стандартын дагуу устгах ажлыг зохион байгуулж ажилласан. 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Салхит уурхайн үйл ажиллагаанаас нийт 40988 кг аюултай хог хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК, Элемент

					<p>ХХК, “Ариун хими” ХХК зэрэг мэргэжлийн байгууллагуудад гэрээний дагуу нийлүүлж устгуулсан.</p> <p>2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргатай Хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу уурхайн хог хаягдлыг 2024 онд нийт 15 удаа тээвэрлэлт хийж 42 дамп хогийг Гурвансайхан сумын хогийн цэгт асгах, зөөн тээвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Нийт 880 тонн хогийг тээвэрлэж төвлөрүүлсэн. Тус ажилд Гурвансайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч тогтмол хяналт тавьж, хамтран ажилласан.</p>
2	<p>Хог хаягдлын цэгүүдийг дахин боловсруулах, ахуйн, аюултай хог хаягдлын цэгүүдийг тохижуулах ажлыг үргэлжлүүлэх</p>	Уурхайн талбайд	24'800'000	<p>Төвлөрсөн хогийн цэгийг стандартын дагуу тэмдэгжүүлсэн байна.</p>	<p>Аюултай хогийг цэгийг тохижуулах ажлын хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Хог хаягдлын менежментийн хэсэгт тусгагдсаны дагуу тендер зарлаж “Аз металл” ХХК-иар хаягдал тос хаях цэгийг хөрсөнд нэвчихээс сэргийлж 10x20 метрийн буюу 200 метр квадрат талбайг бетонжуулж, 25 тонны багтаамжтай хаягдал тос хуримтлуулах ёмкостыг байрлуулж бага хэмжээтэй савнуудад</p>

					хуримтлуулж байсан хаягдал тосыг нэгтгэж зориулалтын саванд зөөвөрлөн хийх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2 ширхэг хуванцар преслэгчийг худалдан авч суурилуулсан. Ахуйн болон аюултай хог хаягдлын цэгийн хүрээгээр үерийн уснаас хамгаалсан шуудуу татаж, хөмсөгжүүлэн өндөрлөж, ачиж тээвэрлэхэд хялбар болгож засварлах зэрэг ажлуудыг хийж тохижуулсан.
3	Дахин боловсруулах боломжтой болон аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад хандаж тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	Уурхайн талбайд	500'000	Мэргэжлийн байгууллагад тушаах ажлыг зохион байгуулж, судалгааг хийсэн байна.	<p>Баяжуулах 1, 2 дугаар үйлдвэрүүдээс гарч буй химийн бодисын сав баглаа боодол, Химийн лаборатори болон бусад үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлууд:</p> <ul style="list-style-type: none"> • Баяжмалын цамц -8540 кг • бодисын шуудай 993кг+2755 кг=3748 кг • химийн бодисын бочка 99 ширхэг, • хаягдал ажилласан тос 13000 кг • Лабораторийн аюултай хог хаягдал: 15700 кг <p>2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Салхит уурхайн үйл ажиллагаанаас нийт 40988 кг аюултай хог хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК, Элемент</p>

					ХХК, “Ариун хими” ХХК зэрэг мэргэжлийн байгууллагуудад гэрээний дагуу нийлүүлж устгуулсан.
4	Хогийг анхан шатанд нь ангилан, ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлэх	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Туслан гүйцэтгэгч компаниудаас гарч байгаа хог хаягдлыг ангилан, ялгаж дахин ашиглах ажлыг зохион байгуулж ажилласан байна.	Уурхайн туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанаас гарч буй дахин боловсруулагдах хог хаягдлыг ангилуулан төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэх ажлыг зохион байгуулж хяналт тавьсан. Мөн дахин ашиглах хог хаягдлыг тохижилт, аж ахуйн шинжтэй ажлуудад дахин ашиглаж ажилласан.
5	Орон нутаг, сумын удирдлагатай Хог хаягдлын гэрээ байгуулан тогтмол хугацаанд тээвэрлэж байх	Уурхайн талбайд	3'600'000	Хог хаягдлын гэрээ байгуулан тогтмол хугацаанд тээвэрлэсэн байна.	Гурвансайхан сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 02-нд байгуулсан гэрээний дагуу сунгалтыг 1 жилээр хийж Гурвансайхан сумын татварын орлогын дансанд 3'600'000 төгрөгийг төвлөрүүлсэн.
6	Энгийн, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж орон нутгийн дахивар	Уурхайн талбайд	200'000	Орон нутгийн дахивар авах цэгтэй хамтран ажилласан байна.	Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж орон нутгийн дахивар авах цэгт тушаах ажлын хүрээнд ундаа усны хуванцар савыг төвлөрүүлж Дундговь аймагт үйл ажиллагаа явуулдаг “Баялаг төв”-д нийлүүлсэн.

	авах цэгт тушаах				
7	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж, санхүүгийн акт үйлдсэний дараагаар дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх талаар судлах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Хог хаягдлыг устгах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх зөвшөөрөлтэй холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.	Хог хаягдлын цэгүүдийн байршлыг тодорхойлж, дахин боловсруулах, ахуйн, аюултай хог хаягдлын цэгүүдийг шинээр байгуулсантай холбоотойгоор уурхайн бүсэд өөр өөр байршлуудад түр хадгалагдаж байсан аюултай, дахин боловсруулах боломжтой хог хаягдлуудыг шинээр байгуулсан хогийн цэгт төвлөрүүлэхдээ тооллого судалгааг албажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг уурхайн бүсээс зөөж тээвэрлэх шийдвэр төрийн өмчийг зохицуулах төрийн байгууллагад танилцуулагдаж шийдвэрлэх үйл ажиллагаа эцэслэгдээгүй.
8	Хог хаягдлын бүтэц, хэмжээг тодорхойлсон тооллого судалгаа хийх	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тооллого судалгааг хийсэн байна.	Уурхайн ахуйн болон аюултай хог хаягдлын цэгүүдийг төрөлжүүлэн шинээр байгуулсантай холбоотойгоор зөөж төвлөрүүлэх үед тооллого хийж, хог хаягдлын бүтцийг тодорхойлсон. Аюултай болон дахин боловсруулах

	Аюултай хог хаягдлын нэгдсэн тооллого зохион байгуулж, бүртгэлжүүлэх	Уурхайн талбайд	-	Тооллого судалгааг хийсэн байна.	<p>боломжтой хог хаягдлын төвлөрсөн цэгт хуримтлагдсан хог хаягдлын тоо хэмжээ:</p> <p>Хаягдал тос 18 тонн</p> <p>Хаягдал дугуй 1000 ширхэг /том оврын/</p> <p>Хаягдал төмөр 50 тонн</p> <p>Байгаль орчны журмуудын хүрээнд үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлыг хавсралт маягтын дагуу тоон мэдээллийг сар, улирал, бүтэн жилээр гаргаж нэгдсэн тоон мэдээллийг нэгтгэж БОХ маягтын дагуу Дундговь аймгийн Байгаль орчны газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилладаг.</p>
9	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулна /үндсэн болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниуд/	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Орчны өнгө үзэмж сайжирч, эмх цэгцтэй болно	Их цэвэрлэгээний хуваарийг уурхайн захирлаар батлуулж туслан гүйцэтгэгч компаниудад хүргүүлж ажилласан. Нийт 56 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг кемп, оффис, баяжуулах үйлдвэрт зохион байгуулж ажилласан. Мөн туслан гүйцэтгэгч компаниудын тус бүр цэвэрлэгээ хийх талбайн зураглал хийж хүргүүлж ажилласан.

10	Уурхайн ахуйн хог хаягдлыг Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэг рүү зөөж тээвэрлэх	Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэгт	9'849'000	Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж ажилласан байна.	2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргатай Хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу уурхайн хог хаягдлыг 2024 онд нийт 15 удаа тээвэрлэлт хийж 42 дамп хогийг Гурвансайхан сумын хогийн цэгт асгах, зөөн тээвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Нийт 880 тонн хогийг тээвэрлэж төвлөрүүлсэн. Тус ажилд Гурвансайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч тогтмол хяналт тавьж, хамтран ажилласан.
11	Тусгай хамгаалалттай газраар дайран өнгөрөх зам дагуу болон Салхит уурхайгаас Дэлгэрцогт сум хүртэлх авто замын дагуух хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	Технологийн зам	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан байна.	2024 онд нийт 1 удаагийн их цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан.
			35'340'000		



Аюултай хогийг цэгийг тохижуулах ажлын хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Хог хаягдлын менежментийн хэсэгт тусгагдсаны дагуу тендер зарлаж “Аз металл” ХХК-иар хаягдал тос хаях цэгийг хөрсөнд нэвчихээс сэргийлж 10х20 метрийн буюу 200 метр квадрат талбайг бетонжуулж, 25 тонны багтаамжтай хаягдал тос хуримтлуулах ёмкостыг байрлуулж бага хэмжээтэй савнуудад хуримтлуулж байсан хаягдал тосыг нэгтгэж зориулалтын саванд зөөвөрлөн хийх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2 ширхэг хуванцар преслэгчийг худалдан авч суурилуулсан. Ахуйн болон аюултай хог хаягдлын цэгийн хүрээгээр үерийн уснаас хамгаалсан шуудуу татаж, хөмсөгжүүлэн өндөрлөж, ачиж тээвэрлэхэд хялбар болгож засварлах зэрэг ажлуудыг хийж тохижуулсан.

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Эрдэнэс алт ресурс ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2023 оны орчны хяналт шинжилгээндээ уст 8 цэгт хэмжилт шинжилгээг явуулах бөгөөд усан хангамжийн гүний худаг, малчны худгаас ерөнхий химийн, бохирдлын шинжилгээг авч итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлсэн. Энэхүү зардалд 940.0 мян.төг, хөрсөн бүрхэвчийн шинжилгээнд нийт 8 цэгээс хөрсний ерөнхий хими, 3 цэгээс хүнд метал, 1 цэгээс бактериологийн дээжийг жилд 4 удаа авах бөгөөд нийт 21 ширхэг дээж авч 1050.0 мян.төг, агаарын чанарын хэмжилтийн зардалд нийт тоос, SO, NO зэргийг 3 цэгт хэмжилт хийх зардалд 88.0 мян.төг төлөвлөсөн. Нийт “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2023 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт **11,934,000** төг зарцуулсан.

Хүснэгт 1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Агаарын чанар, дуу чимээ						
SO ₂ NO ₂ Нийт тоос PM ₁₀	бүзүүлэлт*4 байршил	Үйлдвэрийн бутлуурын хэсэг, тээвэрлэлтийн	Жилд 2 удаа	1 байршил 20 минутын хэмжилт 36.0 мян.төг	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий Шаардлага	PM2.5- 50 мкг/м ³ 24 цаг, 25 мкг/м ³ жил

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
дуу чимээ		зам, ил уурхайн карьер, хаягдлын далан, шатахуун түгээх станц, Аглаг кемп, Сидар кемп, ЭСР кемп		<p>Нийт 4 байшилд жилд 2 удаа 288.0 мян.төг</p> <p>Томилолтын зардал 600.0 мян. төв лаборатори төг</p> <p>Нийт 888.0</p>	<p>MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага</p> <p>MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга</p> <p>MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох Фотоколориметрийн арга</p> <p>MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын</p>	<p>PM10- 100 мкг/м³ 24 цаг, 50 мкг/м³ жил</p> <p>SO2-20 мкг/м³ 24 цаг, 10 мкг/м³ жил</p> <p>NO2-40 мкг/м³ 24 цаг, 30 мкг/м³ жил</p> <p>CO-30000мкг/м³ 1 цаг, 1000 мкг/м³ 8 цаг</p>

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
				¹ Байгаль орчны хэмжилзүйн лаборатори	зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	Pb-1 мкг/м ³ 24 цаг, 0.5 мкг/м ³ жил
Усан орчин						
Усны ерөнхий хими, бактерлогийн шинжилгээ(pH, EC, TDS, нийт шүлтлэг, рН, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ ,	107.00 4	45.870 3	1, 2, 4-р худаг, 1-р усан сан, 3-р усан сан, хаягдлын далан, Аглаг кемп, Сидар кемп, Эрдэнэс силвер ресурсын кемп, бохир усны хаягдал,	Усны ерөнхий химийн шинжилгээ 46000 төг, Цэвэрлэгдсэн бохир усны шинжилгээ 48000	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 0900:2005 Ундны усны стандарт MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээж авах, хадгалах, хамгаалах арга MNS 3534-83	PH-6.5-8.5 NH ₄ -N 0.5 мгN/л, NO ₂ -N 0.2 мгN/л, NO ₃ -N 9.0 мгN/л, PO ₄ -P 0.1 мгP/л, Cl 300мг/л, F 1.5 мг/л, SO ₄ 100мг/л, Mn 0.1 мг/л, Ni 0.01
	107.00 4	45.870 3				
	106.97 5	45.878 4				
	106.98 7	45.850 5				
	106.98 7	45.850 3				
	106.99	45.847				
			Жилд 2			

¹ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 05 сарын 06 –ны өдрийн А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний үнэ тариф

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо		Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	2	3					
СО ₂ , НСО ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий хими, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, рН, хүнд металлын шинжилгээ (As, U, Pb, W, Th, Sn, Cs, Cd, Nb, Se, Zn, Zr)	106.98	45.849	малчны худаг/ удаа	10 цэгт *2 удаа* 94 төг 1,880,0	(Усны шинжилгээнд зориулж дээж авах) Усны анхан шатны тоо бүртгэл хөтлөх журам Усны тоо бүртгэлийн тайлан гаргах журам	мг/л, Cu 0.01 мг/л, Mo 0.25, Cd 0.005 мг/л, Co 0.01 мг/л, Pb 0.01 мг/л, As 0.01 мг/л, Cr 0.05 мг/л, Cr6+ 0.01 мг/л, Zn 0.01 мг/л, Hg 0.1 мг/л, Эрдэс тос 0.05 мг/л, фенол 0.001 мг/л, ГИНБ 0.1 мг/л, Benzo(a) pyren 0.005 мкг/л	
	6	5					
	107.00	45.861					
	1	1					
	106.99	45.871					
9	6						
107.00	45.871						
1	6						
Хөрсний чанар							
Ялзмаг, рН,	106.98	45.85	\ Үйлдвэрийн	Жилд 1	25.0	MNS 5850:2008	Хар тугалга (Pb)

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо		Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
давсжилт, P ₂ O ₅ , K ₂ O, Ширхэгийн бүрэлдэхүүн	7		урд 2, хаягдлын далангийн урд, баруун, баруун хойно, зүүн, хойно тус бүр 1, колонкын урд 1, 2 дугаар постны баруун урд 1, аглаг кемпийн урд 1, уурхайн зүүн хойно 1 /	удаа	25.0*10=250.0	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт MNS5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт,	100, Кадмий (Cd) 3, Мөнгөн ус (Hg) 2, Мишъяк (As) 6, Хром (Cr) 150, Зургаан валентат хром (Cr6+) 4, Цагаан тугалга (Sn) 50, Стронций (Sr) 800, Ванадий (V) 150, Зэс (Cu) 100, Никель (Ni) 150, Кобальт (Co) 50, Цайр (Zn) 300, Молибден (Mo) 5,
Хөрсний биологийн бохирдлын үзүүлэлт	106.98	45.848		Жилд 1 удаа	40.0		
Хөрсний хүнд металлын бохирдол (Pb), (Cr), (Zn), (Ni), (Cd), (ГЗХ, БОХЗТЛ)	7	9		Жилд 1 удаа	50.0		
	106.99	45.847					
	106.99	7					
	106.99	45.847					
	106.99	4					
	4	45.846					
	106.99	45.847					
	8	3					
106.99	45.833						
7	4						
106.98	45.844						
6	8						
106.98	45.849						
6	4						
107.00	45.860						
3	3						
107.00	45.872						
7	6						

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
					<p>MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага</p> <p>MNS5546:2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага</p>	<p>Селен (Se) 10, Бор (B) 25, Фтор (F) 200, Цианид (Cn) 25 мг/л, Тиофенол, фенол 4, газрын тосны бүтээгдэхүүн 2 мг/кг</p>

Ургамлан нөмрөг

Ургамлан нөмрөгийн тархалт, бүрэлдэхүүн, хэвшинж, төрөл зүйлийн бүтцийг тодорхойлох	106.98 6	45.844 9	Тээвэрлэлтийн зам дагуу 1, үйлдвэрийн урд 1, үйлдвэрийн хойно 1, уурхайн өдөр тутмын үйл ажиллагааны замын урд 1,	Жилд 1 удаа	Хээрийн судалгаа, суурин судалгаа	Мод үржүүлгийн талбайд тарималжуулж болох нутгийн унаган ургамлын үрийг түүх	
	106.98 5	45.845 1					
	106.98 6	45.845 3					
	106.99 5	45.836 3					
	106.99	45.835					

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүү д	Дээж авах цэгийн тоо		Дээж авах байршил	Хугаца а ба давтам ж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	4	5	уурхайн хашааны гадна 1 дээж талбай сонгосон.				
НИЙТ ЗАРДАЛ					11'394'000		

Орчны хяналт шалгалтын хөтөлбөрийн хүрээнд:

Салхитын алт – мөнгөний уурхайн орчны агаарын чанарын мониторингийн судалгаа

1. Ерөнхий мэдээлэл

Хүдэр бүхий элс олборлох үйл ажиллагаа нь хэд хэдэн үе шатуудыг дамжихаас гадна, үйл ажиллагааны төрлөөс хамааран хүрээлэн байгаа орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь харилцан адилгүй байна. Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа дизель түлшээр ажилладаг хүнд машин механизмуудын хаягдал утаа, уурхайн барилга байгууламжийн халаалтын зуухнуудын хаягдал утаа нь орчны агаар дахь хий төлөвт бохирдуулах бодисуудын агууламжийг нэмэгдүүлэх бол уурхайн олборлох, тээвэрлэх, баяжуулах үйл ажиллагааны үед орчны агаар дахь тоос тоосонцрын агууламж нэмэгдэнэ.

2. Төслийн талбай дахь агаар бохирдуулах эх үүсвэрүүд

Уурхайн олборлох үйл ажиллагаа нь өөрөө тоос тоосонцрын эх үүсвэр болох ба олборлох үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа машин тоног төхөөрөмжийн хаягдал утаа нь цэгэн болон шугаман эх үүсвэр болдог. Уурхайгаас гарах хаягдал болон хүдрийг тээвэрлэх үйл ажиллагааны үед тээврийн замаас их хэмжээний тоосжилт үүсэх ба уурхайн хэмжээнд үүсэж байгаа нийт тоосны 70-90% үүсэж байдаг. Мөн дизель түлшээр ажилладаг хүнд механизмуудын хаягдал утаанд азотын ислүүд болон хөө тортог, тоног төхөөрөмжийн ажиглалтын байдлаас шалтгаалан нүүрстөрөгчийн дутуу исэл гэх мэт бусад бохирдуулах бодисууд ялгарна.

Төслийн талбайд орших өөр нэг эх үүсвэр нь баяжуулах үйлдвэр болон төв кемпийн халаалтын зуухнууд бөгөөд төсөл хэрэгжүүлэгчийн ирүүлсэн мэдээллээр жилд ойролцоогоор 1000 тн түүхий нүүрсийг түлж хэрэглэдэг байна. Нүүрсний шаталтаас хүхэрлэг хий, тоос тоосонцор, азотын давхар ислүүд зэрэг агаар бохирдуулах бодисууд ялгарах ба орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дээрх эх үүсвэрүүдээс ялгарах агаар бохирдуулах бодисуудыг төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын хүрээнд тодорхойлохыг зорьсон.

3. Агаар бохирдуулах бодисуудын тодорхойлолт

Агаарын чанарын хяналт шинжилгээнд ихэвчлэн түлшний шаталтаас үүдэлтэй зарим бохирдуулагч бодисуудыг сонгон тодорхойлдог. Эдгээрээс хамгийн түгээмэл илэрцтэй бохирдуулагч бодисууд нь тоос тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл юм.

Хүхэрлэг хий SO₂ - Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий. Нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан бүх төрлийн түлшний шаталт, металл боловсруулах үйл ажиллагааны дүнд үүсдэг. Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдэх нь олон талын сөрөг нөлөөлөлтэй ба өндөр агууламжтай үед гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар исэл нь амьсгал цочроосноос найтаах, ханиах зэрэг физиологийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээдэг. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг. Мөн хүчиллэг тунадас (H₂SO₄) үүсгэх зэргээр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, дэд бүтэц зэрэг бүхий л салбарт сөргөөр нөлөөлдөг.

Азотын давхар исэл NO₂ –Азотын давхар исэл нь азот агуулсан түлшний шаталт болон өндөр температурт шаталтын бүтээгдэхүүн бөгөөд ихэвчлэн шаталтын үеийн дулаан шингээх урвалын үр дүнд үүсдэг өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

Тоосонцор (PM_{1.0}, PM_{2.5}, PM_{4.0}, PM₁₀, нийт тоос TSP). Агаарын чанарын судалгаанд тоос тоосонцор гэдэг нь маш өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүсэж буй эх үүсвэр, агаар мандал дахь физик химийн урвалаас хамаараад маш жижиг буюу нано хэмжээнээс эхлээд хэдэн арван микрон хүртэлх ширхэглэгийн хэмжээтэйгээр илэрдэг.

Байгалийн эрдэс минералууд болон биологийн гаралтай тоос тоосонцор харьцангуй том ширхэглэгийн хэмжээтэйгээр агаар мандалд илэрдэг бол бүх төрлийн түлшний шаталтаас үүдэлтэй тоосонцор нь хэмжээний хувьд маш жижиг байхаас гадна хортой химийн элементүүдийг агуулж байдаг. 10 микроноос том ширхэгтэй тоос тоосонцор нь хамар ам, мөгөөрсөн хоолойд баригдаж гадагшилдаг бол 10 микроноос бага диаметртэй тоос/PM₁₀/-ны ширхгүүд нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2.5-10 микрон диаметр бүхий тоосны ширхгүүд нь уушгины мөгөөрсөн хоолой болон хялгасан судлуудад хуримтлагдах, харин 2.5 микроноос бага диаметртэй ширхгүүд нь уушгины цулцангуудад шигдэх аюултай байдаг.


4. Судлагдсан байдал

Уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш хийгдсэн байгаль орчны төлөв байдлын болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангуудад төслийн талбай орчмын агаарын чанарын төлөв байдлын талаар авч үзсэн байдаг. Төслийн талбай орчим ямар нэг суурин газар болон агаар бохирдуулах байнгын эх үүсвэр байхгүй тул төслийн үйл ажиллагаанаас үүсэх агаар бохирдуулах бодисууд нь орчны агаарын чанарыг тодорхойлох гол хүчин зүйл болно. 2017, 2020, 2022 онуудад хийгдсэн байгаль орчны төлөв байдлын судалгаагаар төслийн талбай орчимд агаар бохирдуулах бодисуудын агууламж болон дуу шуугианы түвшин Монгол улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016- д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байсан байна. Манай улсын байгаль орчны бодлогын баримт бичигт уурхай болон үйлдвэрийн газруудын орчны бүсийн хил хязгаарыг журамласан ямар нэг баримт бичиг байхгүй тул зарим хэмжилтийн цэгүүдийг ажлын байрны орчин гэж авч үзэх боломжтой юм. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS4990:2015-д аэродинамик диаметр нь 4 микроноос жижиг тоосонцор(PM4.0)-ын 8 цагийн өртөлтийн зөвшөөрөгдөх хэмжээг цахиурын ислийн найрлагаас нь хамааруулан $0.050-3 \text{ мг/м}^3$, нийт тоосны 8 цагийн өртөлтийн зөвшөөрөгдөх хэмжээг $2-10 \text{ мг/м}^3$ хооронд тогтоосон байдаг.

Төслийн талбайн байршилтай холбогдуулан авч үзэх нэг асуудал нь шороон шуурга юм. Хүчтэй салхи болон түүнтэй холбоотой үүсдэг шороон шуурга нь хөрс элэгдэх, агаарын булингаршил ихсэж алсын бараа муудах, агаар бохирдуулах нөлөөтэй. Шороон шуурганы үед агаарт хөөрсөн элс, тоос, шороо ихээхэн газар нутаг дээр буух тохиолдол ажиглагддаг. Шороон шуурганы улмаас хуурай хөрсний өчүүхэн жижиг ширхэгтэй тоос, шороо, элс, биологийн гаралтай эгэл хэсгүүд газрын гадаргаас агаарт хөөрөхийг агаарт дэгдсэн тоос гэнэ. Энэ нь салхины хурд огцом сулрах үед заримдаа агаарын температур ихэссэн үед ажиглагддаг. Ийм тоос алсын барааны харагдацыг 6 км хүртэл ба түүнээс багаар бууруулна. Шороон шуурга нь салхины хурдны хэмжээ, хөрсний гадаргуугийн шинж чанараас хамаарч үүсдэг. Шороон шуурга голдуу өдрийн цагт ажиглагддаг учир агаарын харьцангуй чийгшил нэлээд бага, ихэвчлэн 20-40 % байхад ажиглагддаг байна. Монгол орны тал, хээр говийн бүс нутагт шороон шуурга тодорхой илэрсэн хоногийн явцтай. Шороон шуурганы хоногийн явцыг авч үзвэл өдрийн цагт ихсэж, шөнийн цагт багасдаг зүй тогтолтой. Өдрийн цагт хөрс халахтай уялдан агаарын тогтворгүйшил ихсэж салхины хурд ихсэж шороо босох нь их байх ба шөнийн цагт эсрэг байдаг. Шороон шуурганы хоногийн явцаас үзвэл өглөөний 9 цагаас оройн 9 цагийн хооронд 75 %-ийн, оройн 21 цагаас өглөөний 9 цагийн хооронд 25 %-ийн, өдрийн 12 цагаас 18 цагийн хооронд 44.1 %-ийн давтагдалтай ажиглагддаг байна.


Төслийн талбай нь хүчтэй салхины давтагдал харьцангуй дунд зэрэг буюу 15м/с -с дээш хурдтай салхитай өдөр жилд 30-40 удаа тохиолддог бүс нутагт

хамаарч байна (Зураг 1). Иймд хүчтэй салхитай өдөр уурхайн үйл ажиллагаанаас тоосжилт үүсдэг байж болох юм.



Зураг 1 Монгол орны хүчтэй салхины давтагдал, хоногоор

Шороон шуурганы давтагдлыг авч үзвэл төслийн талбай орчим жилд 10-30 удаа шороон шуурга ажиглагддаг байна (Зураг 2).



Зураг 2 Монгол орны шороон шуурганы давтагдал, хоногоор

Иймд хавар, намрын хуурай улиралд шороон шуурга шуурах үед агаар дахь тоосны агууламж эрс нэмэгдэж орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүсэж болно.

5. Судалгааны аргазүй

Хот суурин газар болон аливаа нэг төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн агаарын чанарыг үнэлэх эхний шат бол агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг тодорхойлж холбогдох стандарттай харьцуулан үнэлэх явдал юм. Агаарын чанарыг үнэлэх цэгийн тоо болон хэмжилтийн давтамж тухай төслийн цар хүрээ, агаар бохирдуулах эх үүсвэрүүдийн онцлогоос ихээхэн хамаарах ба олон улсын туршлагаас харахад дараах аргуудаас сонгон ашигладаг байна.

- Тогтмол хугацаанд байнгын ажиглалт хийх
- Шаардлагатай үед явуулын судалгаа хийх
- Тодорхой эх үүсвэрүүдээс агаарт хаягдаж буй хаягдлыг хэмжих
- Үйлдвэрийн аваар ослын үеийн хяналт хийх зэргээр агаарын дээжид анализ хийж дүгнэн гаргадаг байна.


Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд агаарын чанарын шинжилгээг дор дурдсан аргачлалуудаар гүйцэтгэж, үр дүнг Монгол улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулан дүгнэсэн.

Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламжийг харгалзан MNS 17.2.5.11, MNS 17.2.5.12 аргачлалуудаар тодорхойлсон бөгөөд агаараас хийн сорьц авахад Япон улсын Sibata компанийн MP300 багаж, лабораторийн химийн шинжилгээнд гэрэл зүйн нягтыг хэмжихэд UNICO 1200 спектрофотометрийг тус тус ашиглана.

Хүхэрлэг хий. Төслийн талбай орчмын агаараас 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд соруулахад шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозанадины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчигчдийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлдог.

Азотын давхар исэл. Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяк хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан авахад шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанадины хүчилтэй

харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь α -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.



Зураг 3 а) Агаар соруулах насос б) зориулалтын шингээгч гуурс в) спектрофотометр

Тоос тоосонцор. Агаар дахь тоосны агууламжийг DustTrak 8533 загварын зөөврийн автомат багажуудаар тодорхойлсон бөгөөд энэ төрлийн багаж нь агаар дахь нийт тоос, PM10, PM4.0, PM2.5, PM1.0 хэмжээтэй тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг тодорхойлох боломжтой.



Зураг 4 Агаар дахь тоос хэмжигч багаж DustTrak 8533

Судалгаанд ашиглагдсан тоос хэмжигч багаж нь АНУ-ын TSI корпорацийн бүтээгдэхүүн бөгөөд DustTrak 8533 загварын хувьд агаар дахь тоос тоосонцрыг ширхэглэгийн хэмжээнээс нь хамааруулан сонгомол хэлбэрээр тодорхойлдог. Уг багажийн ажиллах зарчим нь агаарын сорьцыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар соруулан оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн сарнил тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй агаар дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдагт үндэслэдэг. Харин сарнисан гэрлийн эрчимшил нь тоос тоосонцрын ширхэглэгийн тухай мэдээллийг өгдөг.


Дуу шуугиан хэмжигч. Энэ удаагийн судалгаанд PCE 322 загварын зөөврийн дуу шуугиан хэмжигч багаж ашигласан ба энэхүү төхөөрөмж нь хүний чихний сонсголын хүрээний болон сонсголын бус хүрээний шуугианы түвшнийг хэмжих боломжтой.



Зураг 5 Дуу шуугиан хэмжигч багаж

6. Төслийн талбай орчмын агаарын чанар

Төслийн талбай нь Дундговь аймгийн Гурвансайхан нутаг дэвсгэрт байрлах ба Улаанбаатар хотоос урд зүгт 280 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 60 км-т, Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км зайд байрлана. Төслийн талбай орчим байнгын ажиллагаатай агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэр байхгүй, гол бохирдуулах эх үүсвэр нь уурхайн олборлох, баяжуулах үйл ажиллагаа болон үйлдвэр, кемпийн халаалтын зуухны хаягдал утаа, элэгдэл эвдрэлд өртсөн талбайн тоосжилт юм.



Зураг 6 Төслийн талбайн байршил, хамрах хүрээ

Төслийн байгаль мониторингийн ажлын хүрээнд 2024 оны 09 болон 10 дугаар сард агаарын чанарын хэмжилтийн хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнг Хүснэгт 1-р үзүүлэв.

Хүснэгт 2 Төслийн талбайн агаарын чанарын үзүүлэлтүүд, 2024 оны 09 сар

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл			Дуучимээ
					мг/м ³			
1	Кемп орчим	2024.09.05	16:10	0.016	0.024	0.384	54	
2	Хуурай хаягдалын цэгээс	2024.09.05	16:40	0.011	0.020	0.270	68	
3	Хаягдалын далан орчим	2024.09.05	17:20	0.008	0.028	0.160	50	
4	Тээврийн зам дагуу	2024.09.05	17:45	0.013	0.023	0.384	66	

5	Офисс орчим	2024.09.05	09:25	0.010	0.015	0.159	50
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60
(20 минутын хэмжилт)							
6	Баяжуулах үйлдвэр дотор	IX/06	10:10	0.018	0.045	0.600	90
7	Баяжуулах 2-р үйлдвэр дотор	IX/06	10:40	0.016	0.034	0.394	95
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015				2	2	2	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 (8 цагийн дундаж)							85


Хүснэгт 3 Төслийн талбайн агаарын чанарын үзүүлэлтүүд, 2024 оны 10 сар

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимэг
							ДБА
					мг/м ³		
1	Кемп орчим	X/03	08:10	0.017	0.023	0.053	42
2	Хуурай хаягдалын цэгээс	X/03	08:40	0.014	0.015	0.115	36
3	Хаягдалын далан орчим	X/03	09:10	0.011	0.026	0.114	41
4	Тээврийн зам дагуу	X/03	09:50	0.019	0.021	0.134	31
5	Офисс орчим	X/03	10:30	0.014	0.030	0.103	45
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60
(20 минутын хэмжилт)							
6	Баяжуулах үйлдвэр дотор	X/03	11:00	0.015	0.036	0.220	64

7	Баяжуулах 2-р үйлдвэр дотор	X/03	11:30	0.013	0.023	0.193	78
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015				2	2	2	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 (8 цагийн дундаж)							85


2024 оны 9 болон 10 дугаар саруудад хийсэн хэмжилтийн дүнгээр уурхайн гадаад орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж 0.008-0.019 мг/м³, азотын давхар ислийн агууламж 0.015-0.030 мг/м³, нийт тоосны агууламж 0.053-0.384 мг/м³ байсан нь Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4585:2016-д заасан нэг удаагийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага, баяжуулах үйлдвэрүүдийн дотоод орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж 0.013-0.018 мг/м³, азотын давхар ислийн агууламж 0.023-0.045 мг/м³, нийт тоосны агууламж 0.193-0.600 мг/м³ хязгаарт буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчны эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт ажиглагдсан байна. Харин дуу шуугианы түвшин баяжуулах үйлдвэрийн дотоод орчинд 2024 оны 9 дүгээр сарын хэмжилтээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, шуугианы норм аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байгаа тул ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангах, эрүүл мэндийн үзлэг үйлчилгээнд тогтмол хамруулж байх шаардлагатай. 2022 болон 2024 оны мониторингийн үр дүнг Зураг 7, 8, 9-д харьцуулан үзүүлэв.

Хүхэрлэг хийн агууламж хугацаанаас үл хамааран ерөнхийдөө жигд бага илэрцтэй, 2024 оны 9 дүгээр сарын хэмжилтийн дүнтэй харьцуулахад 10 дугаар сард бага зэрэг нэмэгдсэн, 2022 оны 6 дугаар сарын хэмжилтийн дүнтэй ойролцоо хэмжигдсэн байна. Уурхайн бүс дэх хүхэрлэг хийн гол эх үүсвэр нь нүүрсээр ажилладаг халаалтын зуухнууд болон уурхайн хүнд машин механизмууд бөгөөд орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж халаалтын улиралд бага зэрэг нэмэгдэнэ (Зураг 7).



Зураг 7 Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж


Азотын давхар ислийн агууламж мөн хугацаанаас үл хамааран ерөнхийдөө жигд бага илэрцтэй, 2024 оны 10 дугаар сард уурхайн оффис орчим өмнөх хэмжилтүүдтэй харьцуулахад 2 дахин хэмжигдсэн байгаа нь хэмжилт хийх хугацаанд машин тоног төхөөрөмжийн хаягдал утааны нөлөөлөл байсныг харуулж байна. Уурхайн бүс дэх азотын давхар ислийн гол эх үүсвэр нь уурхайн хүнд машин механизмууд бөгөөд орчны агаар дахь азотын давхар ислийн агууламж улирлаас үл хамааран илрэх боломжтой байдаг (Зураг 8).



Зураг 8 Орчны агаар дахь азотын давхар ислийн агууламж


Уурхайн бүсэд үүсэх тоос тоосонцор уурхайн олборлох үйл ажиллагаа ялангуяа тээврийн гол замуудаас үүсэх ба баяжуулах үйлдвэрийн хувьд хүдрийг бутлах, шигших үйл ажиллагааны үед үүсэж байдаг. Хэмжилтийн дүнгээс харахад 2024

оны 9 дүгээр сард агаар дахь нийт тоосны хэмжээ харьцангуй их, 2022 оны 6 дугаар сард хаягдлын далан орчим хамгийн хэмжигдсэн байна (Зураг 9). Тоос тоосонцрын хэмжилтийн үр дүн нь тоосжилтыг бууруулах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлж байгаагаас ихээхэн хамаарах ба уурхайн дотоод хяналтын ажлын хүрээнд тоосжилтыг бууруулах арга хэмжээтэй уялдуулан тоос тоосонцрын хэмжилтийг үр дүнг үнэлэх нь зүйтэй.



Зураг 9 Орчны агаар дахь нийт тоосны агууламж,

Дуу шуугианы хэмжилтийг гүйцэтгэсэн хугацаанд машин механизмуудын хөдөлгөөнөөс хамааран тээврийн зам болон хаягдлын далан орчим бага зэрэг их хэмжигдсэн байна (Зураг 10). Манай улсын хувьд дуу шуугианы нөлөөллийн үргэлжлэх хугацааг өдрийн(07-23) болон шөнийн(23-07) цаг гэж тогтоосон байдаг ба төслийн үйл ажиллагаанаас орчны шуугианы эквивалент түвшинд нөлөөлөх хэмжээ байнгын ажиллагаатай тоног төхөөрөмжүүдээс 300м хүртэлх зайд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага болж буурах боломжтой.




Зураг 10 Орчны шуугианы түвшин

Дүгнэлт

Уурхайн бүсэд хэмжсэн агаар бохирдуулах бодисуудын агууламж Монгол улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын байрны орчны эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байлаа. Тоос тоосонцрын гол эх үүсвэр нь баяжуулах үйлдвэр болон хүнд даацын тээврийн замууд бөгөөд хүчтэй салхи шуурга тоосжилтын нөлөөллийг улам бүр нэмэгдүүлж байна.

Уурхайн тоосжилтыг бууруулах олон арга байдаг. Эдгээрээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь усалгаа боловч нөөцийн асуудал болон эрс тэс цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан хязгаарлагдмал ашиглагддаг. Сүүлийн үеийн судалгаанаас харахад ил уурхайн тоосжилтыг бууруулахад Канад улсын abcdust компанийн DMS-DS төрлийн бодисыг өргөн ашиглаж байна. Энэ бодис нь 0.25 микрон нанополимер болон спиртийн хувийн холимгоос бүрдсэн гадаргуугийн идэвхт бодис бөгөөд тоос тоосонцрын дэгдэлтийг 95-98%-ийг бууруулах ба усаар чийгшсэн замтай харьцуулахад тоормосны барих зайг 35-82%-иар сайжруулдаг. Энэ бодисыг усалгааны машинуудын саванд хольж хэрэглэж болох ба усны зарцуулалтыг 90% хүртэл бууруулж, замын засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг бууруулна.

Бодисын хэрэглээ болон найруулах тунгийн хэмжээ нь зам болон материалын шинж чанараас хамааран өөр өөр байх тул дараах холбоосоор орон дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой. <https://abcdust.net/ds/>



Зураг 11 Төсийн хэрийн судалгааны үеийн хэмжилтийн зургууд

Графикийн жагсаалт

График 1. Хөрсний мониторинг цэгүүд дэх рН-ийн утга 102

График 2. Хөрсний мониторинг цэгүүд дэх карбонатын агууламж 103

График 3. Хөрсний мониторинг цэгүүд дэх ялзмагийн агууламж..... 104

График 4 . Хөрсний мониторинг цэгүүд дэх ЕС-ийн түвшин..... 104

График 5. Хөрсний мониторинг цэгүүд дэх P_2O_5 -ын хангамж 105

График 6. Хөрсний мониторинг цэгүүд дэх K_2O -ийн хангамж..... 105

График 7. Хөрсний мониторинг цэгүүд дэх механик бүрэлдэхүүн 106

График 8. Хөрсний мониторинг цэгүүд дэх As-ийн агууламж..... 108

График 9. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cd-ийн агууламж 109

График 10. Хөрсний мониторинг цэгүүд дэх Pb-ын агууламж 109

График 11. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cu-ийн агууламж 110

График 12. Хөрсний мониторинг цэгүүд дэх Mo-ийн агууламж..... 110

График 13. Хөрсний мониторинг цэгүүд дэх Zn-ийн агууламж..... 111

Зургийн жагсаалт

Зураг 1. Хөрсний мониторинг цэгүүдийн байршил.....	95
Зураг 2. Үйлдвэр кемп баруун хойд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв .	97
Зураг 3. Химийн бодис агуулах цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	97
Зураг 4. Үйлдвэр урд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв.....	97
Зураг 5. Үйлдвэр зүүн урд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	97
Зураг 6. Шимт хөрс-2 гадаргын өнөөгийн төлөв	98
Зураг 7. Хаягдлын сан зүүн цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	98
Зураг 8. Хаягдлын сан урд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	98
Зураг 9. Хаягдлын сан хойд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	98
Зураг 10. Хогийн цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв.....	99
Зураг 11. Үйлдвэр кемпийн “00” хөрсний гадаргын өнөөгийн төлөв	99
Зураг 12. Сидар засварын талбайн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	99
Зураг 13. Шимт хөрс-1 гадаргын өнөөгийн төлөв	99
Зураг 14. Нөхөн сэргээсэн талбайн хөрсний гадаргын өнөөгийн төлөв	100
Зураг 15. Налуулсан чулуулгийн гадаргын өнөөгийн төлөв	100
Зураг 16. Ш.Т.С хөрсний гадаргын өнөөгийн төлөв	100
Зураг 17. Пост-1 “00” хөрсний гадаргын өнөөгийн төлөв	100
Зураг 18. Технологийн зам дагуу цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв ...	101
Зураг 19. Хуурай хаягдлын талбайн гадаргын өнөөгийн төлөв.....	101
Зураг 20. Ахуйн цэвэрлэх байгууламж орчмын хөрсний гадаргын өнөөгийн төлөв	101
Зураг 21. Контрол цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв.....	101

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хөрсний мониторинг цэгүүдийн ерөнхий мэдээлэл.....	96
Хүснэгт 2. Хөрсний мониторинг цэгүүдийн бактерлогийн үр дүн.	106

1. Хөрсний хяналт шинжилгээ

1.1 Судалгааны аргазүй

1.1.1 Хөрсний хээрийн судалгаа

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ний “Салхитын алт мөнгөний орд” төслийн 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний мониторингийн хээрийн судалгаа буюу хөрсний дээж авалтыг 2024.08 болон 10-р сард хоёр удаагийн давталттайгаар авч лабораторийн үр дүнг харьцуулсан байдлаар боловсруулсан. Энэхүү талбайд хөрсний мониторинг хийдэг нийт 21-н цэгээс (Зураг 12, Хүснэгт 4) өнгөн хөрсний буюу 0-10 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдлын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298 : 1990” стандартыг баримталсан.

1.1.2 Лабораторийн задлан шинжилгээ

Хөрсний дээжүүдэд агро-хими, физик шинж, хүнд металл зэрэг 20 орчим үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг “Land owner” ХХК-ний “Green lab” лабораторид тодорхойллоо. Үүнд:

- | | |
|------------------------------|--------------------|
| • Ялзмаг | - Тюриний |
| • Урвалын орчин (pH) | - Потенциометрийн |
| • CaCO ₃ карбонат | - Кальциметрийн |
| • Механик бүрэлдэхүүн | - Гидрометрийн |
| • Давсжилт, ЕС | - Потенциометрийн |
| • Фосфор | - Спектро фотометр |
| • Кали | - Дөлт фотометр |


Хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд бэлтгэж боловсруулахад “Физик химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах. MNS ISO 11464:2002” стандарт, анализ хийхэд “Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310 : 1991” стандартуудыг мөрдлөг болгосон.

Хүнд металл. Хүнцэл (As), Кадмий (Cd), Хром (Cr), Зэс (Cu), Никель (Ni), Хар тугалга (Pb), Мо, Со, Sr, V, Цайр (Zn) зэрэг элементүүдийг олон улсын сүлжээ “SGS Mongolia” лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometer (OS)-ийн багажаар тодорхойлсон.

1.1.3 Зураглал

Хөрсний мониторинг цэгүүдийн байршлын зураглал хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS Pro 3.3 программ дээр ESRI болон Google Map

ашиглан хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг А4 хуудсан дээр шугаман масштабтайгаар бэлдсэн.



Зураг 12. Хөрсний мониторинг цэгүүдийн байршил

Хүснэгт 4. Хөрсний мониторинг цэгүүдийн ерөнхий мэдээлэл

№	Цэгийн дугаар	Хөрсний гадаргын төлөв	Цэгийн солбицол (decimal degree)	
			Х	Ү
1	Үйлдвэр кемп б.хойно	Усаар зөөгдсөн элсэрхэг хучаастай	106.985382	45.849834
2	Химийн бодис агуулах	Технологийн талбай	106.984985	45.851627
3	Үйлдвэр кемп урд	Усаар зөөгдсөн элсэрхэг хучаастай	106.986984	45.849083
4	Үйлдвэр з.урд	Технологийн талбай	106.988350	45.850338
5	Шимт хөрс-2	Бага зэрэг талхадсан	106.993301	45.851196
6	Хаягдал сан зүүн	Технологийн талбай	106.994797	45.850281
7	Хаягдал сан урд	Усаар зөөгдсөн элсэрхэг хучаастай	106.997757	45.846355
8	Хаягдал сан хойд	Бага зэрэг талхадсан	106.990009	45.849960
9	Хогийн цэг	Технологийн талбай	106.993011	45.845577
10	Үйлдвэр кемп "00"	Усаар зөөгдсөн элсэрхэг хучаастай	106.985397	45.848923
11	Сидар засварын төв	Технологийн талбай	107.001259	45.860847
12	Шимт хөрс-1	Бага зэрэг талхадсан	107.006729	45.856224
13	Нөхөн сэргээсэн талбай	Усаар бага зэрэг эвдэрсэн	107.001884	45.863285
14	Чулуулаг	Налуулж нягтаршуулсан	107.001953	45.863632
15	Ш.Т.С	Ердийн	106.998032	45.860966
16	Пост-1 "00"	Бага зэрэг талхадсан	106.996262	45.860062
17	Технологи зам дагуу	Усаар зөөгдсөн элсэрхэг хучаастай	106.996277	45.857555
18	Хаягдал кейк	Технологийн талбай	106.984970	45.850147
19	Цэвэрлэх байгууламж	Усаар зөөгдсөн элсэрхэг хучаастай	107.001381	45.871746
20	Контрол цэг (ердийн хөрс)	Ердийн	107.001053	45.880810

1.2 Судалгааны үр дүн

1.2.1 Хөрсний мониторинг цэгүүдийн гадаргын өнөөгийн төлөв байдал



Зураг 13. Үйлдвэр кемп баруун хойд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 14. Химийн бодис агуулах цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 15. Үйлдвэр урд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 16. Үйлдвэр зүүн урд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 17. Шимт хөрс-2 гадаргын өнөөгийн төлөв



Зураг 18. Хаягдлын сан зүүн цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 19. Хаягдлын сан урд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 20. Хаягдлын сан хойд цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 21. Хогийн цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 22. Үйлдвэр кемпийн "00" хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 23. Сидар засварын талбайн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 24. Шимт хөрс-1 гадаргын өнөөгийн төлөв



Зураг 25. Нөхөн сэргээсэн талбайн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 26. Налуулсан чулуулгийн гадаргын өнөөгийн төлөв



Зураг 27. Ш.Т.С хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 28. Пост-1 "00" хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 29. Технологийн зам дагуу цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 30. Хуурай хаягдлын талбайн гадаргын өнөөгийн төлөв



Зураг 31. Ахуйн цэвэрлэх байгууламж орчмын хөрсний гадаргын өнөөгийн төлөв



Зураг 32. Контроль цэгийн хөрсний гадаргын өнөөгийн төлөв

1.2.2 Хөрсний агро-хими, физик шинж чанар

Хөрсний урвалын орчин (pH)

Энэхүү үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад нэн тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс (График 1) харахад pH-ийн утгын хэлбэлзэл 7.9-9.0 хооронд буюу хүчтэй шүлтлэг орчинтой байгаа нь ургамал ургахад тохиромжтой багатай байна. 8 болон 10-р сарын хэмжилтийн үр дүн хоорондоо хэт их зөрүү багатай буюу хэвийн байна.




График 1. Хөрсний мониторинг цэгүүд дэх pH-ийн утга

Хөрсний карбонатжилт

Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO₃)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонат нь хөрсний pH-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ. Судалгааны үр дүнгээс (График 2) харахад карбонатын агууламж 0.00-2.4%-ийн хооронд буюу маш сулаас дунд зэрэг карбонатжсан байна. Нөлөөлөлд өртсөн цэгүүд харьцангуй илүү карбонаттай байгаа нь шимт хөрсийг

хуулах явцад хөрсний үе давхаргууд холилдож доод үе давхаргын их карбонаттай хөрстэй холилдсонтой холбоотой байна.




График 2. Хөрсний мониторинг цэгүүд дэх карбонатын агууламж

Хөрсний ялзмагийн агууламж

Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Энэ бүс нутаг нь хээрийн бүсэд хамаарах учраас хүний нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсөн бүрхэвч дунджаар 1.0% ялзмагтай байдаг (суурь судалгаа). Судалгааны үр дүнгээс (График 3) харахад ялзмагийн утгын хэлбэлзэл 0.4-0.7%-ийн хооронд буюу маш бага агууламжтай байна. Мөн 8 болон 10-р сарын хэмжилтийн үр дүн хоорондоо хэт их зөрүү багатай, контрол цэгтэй ойролцоо утгатай буюу хэвийн түвшинд байна.




График 3. Хөрсний мониторинг цэгүүд дэх ялзмагийн агууламж

Хөрсний цахилгаан дамжуулалт (ЕС) буюу хялбар уусах давсжилт

ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ЕС нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсний ЕС нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад (График 4) ЕС_{1:2.5}-ийн утгын хэлбэлзэл 0.044-0.144 dS/m хооронд буюу маш сул давсархаг байна. Мөн 8 болон 10-р сарын хэмжилтийн үр дүн хоорондоо хэт их зөрүү багатай, контрол цэгтэй ойролцоо утгатай буюу хэвийн түвшинд байна.




График 4 . Хөрсний мониторинг цэгүүд дэх ЕС-ийн түвшин

Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали (P_2O_5 , K_2O)

Хөрсний фосфор, кали (P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Фосфор нь мөн ургамлын үндэсний өсөлтийг дэмжиж, цэцэглэж ургахад чухал нөлөөтэй байдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P_2O_5) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидаг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь өсөлт хөгжил болон бусад олон процессуудад чухал хэрэгтэй байдаг. Кали нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон

шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K_2O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K_2O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс (График 5) харахад P_2O_5 -ын утгын хэлбэлзэл 1.0-1.9 мг/100г -ийн хооронд буюу хөдөлгөөнт фосфорын хангамж бага байгаа нь харагдаж байна. Хөдөлгөөнт калийн хувьд утгын хэлбэлзэл нь 17-66 мг/100г -ийн хооронд сайн хангамжтай байна (График 6). Мөн 8 болон 10-р сарын хэмжилтийн үр дүн хоорондоо хэт их зөрүү багатай, контрол цэгтэй ойролцоо утгатай буюу хэвийн түвшинд байна.




График 5. Хөрсний мониторинг цэгүүд дэх P_2O_5 -ын хангамж




График 6. Хөрсний мониторинг цэгүүд дэх K_2O -ийн хангамж

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаврынх <0.002мм тус тус байдаг. Хөрсний механик бүрэлдэхүүн нь чийг

багтаамж, нэвчилтийн эрчим, органик бус шим тэжээлийн бодисын хангамж, нягтшил зэрэг олон үзүүлэлтэд маш нөлөөтэй байдаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг. Судалгааны үр дүнгээс (График 7) харахад хөрсөн дэх элсэн фракцын утгын хэлбэлзэл 58-92%, шавар 4.4-11.4%-ийн хооронд буюу том ширхэгтэй элсэн фракц давамгайлсан элсэнцэр болон нарийн элсэн механик бүрэлдэхүүнтэй байна. Энд шимт хөрс-1 цэгийн элсний агууламж өөрчлөлттэй байгаа нь борооны усаар нарийн тоосорхог хэсэг нь бага зэрэг угаагдалд орсныг илтгэж байна.




График 7. Хөрсний мониторинг цэгүүд дэх механик бүрэлдэхүүн

1.2.3 Хөрсний нянгийн бохирдол

Хөрсний бактерлогийн шинжилгээг “Хөрсөнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх арга”, “Гэдэсний бүлгийн савханцар болон байж болох *E.coli*-г илрүүлэх арга” болон “Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үзүүлэлтийн норм, хэмжээ” гэсэн стандартуудын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд хөрсний микробиологийн ерөнхий шинжилгээний стандартад зааснаар дээжид нийт бичил биетний тоо 1 гр-д 10^6 -аас хэтрэхгүй, халдварт өвчин үүсгэгч гэдэсний бүлгийн савханцар (*E.coli*), *Clostridium perfringens*, *Staphylococcus aureus* зэрэг бактериуд илрэх ёсгүй байдаг. Судалгааны үр дүнгээс харахад (Хүснэгт 5) нийт бактерийн тоо бүх цэгүүдэд хэвийн хэмжээтэй илэрсэн байна. Харин *E.coli* савханцар цэвэрлэх байгууламж ба хог хаягдлын цэгт илэрсэн, *Clostridium perfringens* 10-р сарын байдлаар бүх цэгт илэрсэн, *Staphylococcus aureus* бүх илрээгүй байна. Эндээс харахад эдгээр цэгүүдэд бактерийн бохирдол нэмэгдэж байна.

Хүснэгт 5. Хөрсний мониторинг цэгүүдийн бактерлогийн үр дүн.

Дээжийн нэр	Мониторинг давтамж	Бактерийн нийт тоо	Гэдэсний бүлгийн савханцар (<i>E.coli</i>)	<i>Clostridium perfringens</i>	<i>Staphylococcus aureus</i>

Пост-1 "00"	8-р сар	6.0x10 ⁵	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
	10-р сар	2.0x10 ⁵	Илрээгүй	Илэрсэн	Илрээгүй
Цэвэрлэх байгууламж	8-р сар	1.3x10 ⁶	Илэрсэн	Илрээгүй	Илрээгүй
	10-р сар	5.0x10 ⁵	Илэрсэн	Илэрсэн	Илрээгүй
Хог хаягдлын цэг	8-р сар	5.0x10 ⁵	Илэрсэн	Илрээгүй	Илрээгүй
	10-р сар	4.0x10 ⁵	Илэрсэн	Илэрсэн	Илрээгүй
Аглаг-Соёолон "00"	8-р сар	3.0x10 ⁶	Илрээгүй	Илэрсэн	Илрээгүй
	10-р сар	1.0x10 ⁵	Илрээгүй	Илэрсэн	Илрээгүй

1.2.4 Налуулж тэгшилсэн чулуулгийн шинж чанар

Уурхайн хаягдал чулуулгийг биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлдэж стандартын дагуу налуулж тэгшилсэн талбайн хурдас чулуулаг нь ирээдүйд хөрсөнд хүчиллэг үүсгэх эсэхийг шалгах зорилгоор чулуулгаас дээжлэлт хийж эрдсийн найрлага болон урвалын орчныг тодорхойлуулсан. Доорх 8 болон 10-р сард авсан дээжийн шинжилгээний үр дүнгээс харахад чулуулгийн урвалын орчин нь 7.6-8.1 буюу саармагаас сул шүлтлэг, эрдсийн найрлагад кварц 35-58%, альбит 14-16%, кальцит 12% зэрэг суурилаг шинж чанартай эрдсүүд зонхилсон байгаа нь хүчиллэг үүсгэх эрсдэл байхгүй байгааг илтгэж байна. Мөн хүчиллэг нөхцөлийг бүрдүүлдэг хүхэр болон хүхэрлэг эрдсийн агууламж 0.21-0.36% буюу маш бага байна.

Хүснэгт 1. Чулуулгийн (#2) эрдсийн найрлага (XRD)			
№	Эрдсийн нэр	Томьёо	Агуулга (%)
1	Кварц (цахуурын оксид)	SiO ₂	58.93
2	Альбит	NaAlSi ₃ O ₈	16.70
3	Куприт (зэсийн оксид)	Cu ₂ O	1.09
4	Кристалит (цахуурын оксид)	SiO ₂	2.26
5	Мусковит	KAl ₃ Si ₃ O ₁₀ (OH) ₂	3.32
6	Гауллит (цеолитын төрлийн эрдэс)	Na ₄ (Zn ₂ Si ₂ O ₁₄)(H ₂ O) ₅	6.40
7	Браунит (манганы силикат)	(Mn ₂ O ₃) ₃ MnSiO ₃	1.64
8	Накрит	Al ₂ Si ₂ O ₇ (OH) ₄	9.65

Хүснэгт 2. Чулуулгийн (#2) физик, химийн найрлага болон усанд хандалсны дараах найрлага			
№	Химийн үзүүлэлт	Томьёо	Агуулга
			Усанд хандалсны (дээж ус, 1:10, 36 цаг, 30эрг/мин) дараах дээж
Гадаад байдал, физик шинж чанар			
1	Гадаад байдал, өнгө		Хар саарал өнгийн буталсан, хатуу чулуулаг
2	Орчин (хатуу: шингэний харьцаа, 1:10)	pH	8.01 (сул шүлтлэг)
Химийн найрлага (% XRF)			
1	Цахиурын оксид	SiO ₂	65.150
2	Хөнгөнцагааны оксид	Al ₂ O ₃	18.450
3	Магнийн оксид	MgO	1.320
4	Төмрийн (III) оксид	Fe ₂ O ₃	1.180
5	Манганы оксид	Mn ₂ O ₄	1.230
6	Натрийн оксид	Na ₂ O	3.850
7	Калийн оксид	K ₂ O	1.630
8	Зэс	Cu	0.480
9	Фосфор	P	0.040
10	Хүхэр	S	0.290
11	Хүчлэл	As	0.004
12	Кобальт	Co	0.041
13	Цайр	Zn	0.085
14	Стронци	Sr	0.015
15	Хар тугалга	Pb	0.018
16	Кадми	Cd	0.001

Хүснэгт 1. Чулуулгийн (#1) эрдсийн найрлага (XRD)			
№	Эрдсийн нэр	Томьёо	Агуулга (%)
1	Кварц (цахуурын оксид)	SiO ₂	35.09
2	Альбит	NaAlSi ₃ O ₈	14.29
3	Кальцит (кальцийн карбонат)	CaCO ₃	12.59
4	Гоббинсит (цеолитын төрлийн эрдэс)	Na ₂ (Si ₁₁ Al ₅ O ₃₂ · 11H ₂ O	3.22
5	Якобсит (манган төмрийн оксид)	MnFe ₂ O ₄	2.86
6	Браунит (манганы силикат)	(Mn ₂ O ₃) ₃ MnSiO ₃	1.55
7	Мусковит	KAl ₃ Si ₃ O ₁₀ (OH) ₂	0.78
8	Розенит (төмрийн сульфат)	FeSO ₄ (H ₂ O) ₄	4.36
9	Каолинит	Al ₂ (Si ₂ O ₅)(OH) ₄	5.99
10	Анортклаз	(Na _{0.75} K _{0.25})AlSi ₃ O ₈	19.27

Хүснэгт 2. Чулуулгийн (#1) физик, химийн найрлага болон усанд хандалсны дараах найрлага			
№	Химийн үзүүлэлт	Томьёо	Агуулга
			Усанд хандалсны (дээж ус, 1:10, 36 цаг, 30эрг/мин) дараах дээж
Гадаад байдал, физик шинж чанар			
1	Гадаад байдал, өнгө		Хар саарал өнгийн буталсан, хатуу чулуулаг
2	Орчин (хатуу: шингэний харьцаа, 1:10)	pH	7.6 (саармаг)
Химийн найрлага (% XRF)			
1	Кальцийн оксид	CaO	8.050
2	Цахиурын оксид	SiO ₂	50.520
3	Магнийн оксид	MgO	4.460
4	Хөнгөнцагааны оксид	Al ₂ O ₃	26.320
5	Төмрийн (III) оксид	Fe ₂ O ₃	5.200
6	Манганы оксид	Mn ₂ O ₄	1.680
7	Натрийн оксид	Na ₂ O	1.120
8	Калийн оксид	K ₂ O	0.890
9	Фосфор	P	0.051
10	Хүхэр	S	0.361
11	Хүчлэл	As	0.008
12	Кобальт	Co	0.048
13	Стронци	Sr	0.010
14	Хар тугалга	Pb	0
15	Кадми	Cd	0.004

1.2.5 Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшин

Хөрсний хүнд металл гэдэг нь нягт нь 5 г/см^3 -ээс илүү, атом масс нь 40-өөс илүү, хөрсөнд тогтвортой удаан хугацаагаар хадгалагддаг, амьд организмд аюултай хор нөлөө үзүүлдэг, уусах чанар багатай, удаан задардаг био-идэвхт, хортой, онцгой хортой элементүүд юм. Судалгаагаар хөрсний мониторингийн цэгүүдээс авсан өнгөн хөрс (0-10см)-ний дээжүүдэд As, Cd, Co, Cu, Cr, Mo, Ni, Pb, Ni, Sn, Sr, V, Zn гэсэн металлуудыг тодорхойлуулсан. Судалгааны үр дүнгээс харахад дээрх металлуудаас Sn маш бага буюу бараг илрээгүй, Co, Cr, Ni, Sr, V гэсэн металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна (Хавсралт хэсгээс шинжилгээний дэлгэрэнгүйг харна уу!). Харин As, Cd, Cu, Mo, Pb, Zn гэсэн металлууд их бага хэмжээгээр илэрсэн байна. Эдгээр илэрсэн хүнд металлуудын үр дүнг доор дэлгэрэнгүй оруулсан.

Хөрсний хүнцэл (As)

Хүнцэл нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл (арсеноприт) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (График 8) харахад As-ийн утгын хэлбэлзэл 8-371 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний хүнцлийн агууламж зарим цэгүүдэд стандартын хүлцэх, уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх болон аюултай агууламжуудаас хэтэрсэн буюу бохирдол ихтэй байна. Агууламж өндөртэй цэгүүд нь баяжуулах үйлдвэрийн болон хаягдлын сангийн ойр орчимд байрлаж байгааг Зураг 12-ээс харж болно. Харин энэхүү бүсээс хол байрлалтай ШТС болон хяналтын цэгт агууламж хэвийн түвшинд байна.




График 8. Хөрсний мониторинг цэгүүд дэх As-ийн агууламж

Хөрсний кадмий (Cd)

Кадмий нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (График 9) харахад Cd-ийн утгын хэлбэлзэл 0.5-9 мг/кг хооронд байна. Мониторинг цэгүүд дэх хөрсний Кадмийн агууламж стандартын хүлцэх агууламж 5 мг/кг-аас

зарим цэгүүдэд давсан боловч уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн гэж үзэж болохоор байна.




График 9. Хөрсний мониторинг цэгүүд дэх Cd-ийн агууламж

Хөрсний хар тугалга (Pb)

Хар тугалга нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл, сульфид байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (График 10) харахад Pb-ын утгын хэлбэлзэл 24-596 мг/кг хооронд байгаа нь зарим цэгүүдэд уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх хэмжээнээс бага зэрэг давсан боловч аюултай агууламжаас хэтрээгүй байна.




График 10. Хөрсний мониторинг цэгүүд дэх Pb-ын агууламж

Хөрсний зэс (Cu)

Зэс нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (График 11) харахад Cu-ийн утгын хэлбэлзэл бүх цэгүүдэд бага агууламжтай буюу 13-424 мг/кг хооронд байгаа нь стандартын хүлцэх агууламж 100 мг/кг-аас зарим цэгүүдэд давсан боловч уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн гэж үзэж болохоор байна.




График 11. Хөрсний мониторинг цэгүүд дэх Си-ийн агууламж

Хөрсний молибден (Mo)

Молибден нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (График 12) харахад Мо-ийн утгын хэлбэлзэл 0.5-6 мг/кг хооронд байгаа нь агууламж стандартын хүлцэх агууламж 5 мг/кг-аас зарим цэгүүдэд давсан боловч уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн гэж үзэж болохоор байна.




График 12. Хөрсний мониторинг цэгүүд дэх Мо-ийн агууламж

Хөрсний цайр (Zn)

Цайр нь Монгол улсын стандартаар хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн цайрын исэл (ZnO) байдлаар агуулагддаг. Судалгааны үр дүнгээс (График 13) харахад Zn-ийн утгын хэлбэлзэл 52-727 мг/кг хооронд байгаа нь агууламж стандартын хүлцэх агууламж 300 мг/кг-аас зарим цэгүүдэд давсан боловч уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн гэж үзэж болохоор байна.




График 13. Хөрсний мониторинг цэгүүд дэх Zn-ийн агууламж

1.3 Дүгнэлт

- Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь “Эрдэнэс алт” ХХК-ний хэрэгжүүлж буй “Салхитын” уурхайн хөрсний орчны хяналт шинжилгээг 2024 оны 8;10-р сард нийт 20 цэг дээр хөрсний агро-хими ба ус-физик шинж чанар, хүнд металл, хөрсний бактерлоги, чулуулгийн эрдсийн найрлага ба хүчиллэг чанар зэрэг 30 гаруй үзүүлэлтээр тодорхойллоо.
- Нийт 20-н цэгээс 3 цэг нь ердийн буюу ямар нэг эвдрэл, талхагдалд ороогүй, бусад цэгүүд нь уурхайн болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж өнгөн хөрс нь эвдэрч талхадсан болон тоосжилтод өртсөн цэгүүд сонгосон.
- Ахуйн болон техникийн гаралтай хатуу хог хаягдал болон шатах тослох материалаар бохирдож болзошгүй цэгийн хөрсний гадарга дээр мэдэгдэхүйц том хэмжээний бохирдол байхгүй, ганц нэг цэгт тослох материалын жижиг толботой байна.
- Хөрсний агро химийн үзүүлэлтүүд нь өөрчлөлт багатай буюу контрол цэгтэй ойролцоо түвшинд байна.
- Ахуйн цэвэрлэх байгууламж, задгай “00”, хог хаягдлын зэрэг газруудад нянгийн бохирдол нэмэгдэж байгаа учраас аливаа халдварт өвчин дэгдэхээс сэргийлж эдгээр цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байх хэрэгтэй.
- Хөрсний хүнд металлуудын хувьд хүнцэл (As) болон хар тугалганы (Pb) агууламж баяжуулах үйлдвэрийн ойр орчмын бүсэд нэлээд өндөр байгаа учраас баяжуулах үйлдвэр болон хаягдлын сан дээр ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэндэд урт хугацаандаа сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байна. Иймээс үйлдвэрийн бүсийн тоосжилт ихтэй орчинд ажиллаж байгаа хүмүүс нэг бүрийн хамгаалах хэрэгслээ (маск) тогтмол өмсөж хэвших шаардлагатай.



Амьтны аймаг

1.1. Судалгааны аргазүй

“Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт хэрэгжүүлж буй “Салхитын алт-мөнгөний үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн талбай нь Байгалийн бүс бүслүүрийн хувьд **Цөлөрхөг хээрийн бүсэд** хамрагддаг.

Судалгааны талбайн дээрх онцлогийг харгалзан бид амьтны хээрийн судалгааны 2 үндсэн аргачлалыг ашиглан мэдээ баримтыг цуглуулав. Үүнд:

- Цэгэн тооллогын арга зүй
- Шугаман замналын тооллого буюу трансектын арга зүй

Цэгэн тооллогын мониторингийн цэг тус бүрт хээрийн судалгааны хугацаанд дараах ажиглалт, бичиглэлийг гүйцэтгэсэн болно. Үүнд:


- Сээртэн амьтдын зүйл тус бүрийг бүртгэх
- Популяцийн тоо толгой, сүргийн бүтцийг сээртэн амьтдын зүйл тус бүрээр гаргах
- Хөхтөн, шувууны зүйлүүдийн өдрийн идэвхийг ажиглах
- Хөхтөн, шувууны анхаарал татах зүйлүүдийн амьдрах орчны хамаарлыг ажиглах
- Лабораторийн нөхцөлд тодорхойлох боломжтой амьтдын идэш тэжээлийн үлдэгдэл, ялгадас, гулгидас, өд сөд зэргийг цуглуулж, зүйл тодорхойлох
- Гэрэл зураг авч хээрийн судалгааны баримтыг баталгаажуулах.

Судалгаанд бид Leica 60x телескоп, Nikon 10x15 хоёр нүдний дуран, Sony 77 SLR гэрэл зургийн аппарат, Garmin trex GPS болон метр, шугам зэрэг багаж, хэрэгсэл болон дээж цуглуулах пластик уут зэргийг хэрэглэв. Судалгааны баг нь ажиглалтын багаж хэрэгслийнхээ тусламжтай 5 км радиус дотор шувуу, хөхтөний зүйлүүдийг шууд ажиглалтаар тодорхойлох чадвартай бүрэлдэхүүнтэй ажилласан.

Амьтны мөрийг хэмжих арга: Мөр, ялгадас зэрэг тухайн амьтны амьдрах орчиндоо үлдээсэн ул мөрөөс зүйл, хүйс, биеийн хэмжээ, барагцаалсан жин, хоолны дэглэм, амарч хэвтэх зан авир зэргийг тодорхойлж болдог. Тодорхой цаг хугацааны турш зөв тэмдэглэсэн мэдээллээр сүрэг доторх бодгалийн хамгийн бага тоо, идэвхжил, тодорхой зүйлийн улирлын нүүдэл

зэргийг тодорхойлж болно. Үүний тулд тухайн орчинд тохиолдсон амьтны ул мөрийг зөв хэмжиж, бүртгэдэг байх ёстой.

Зураг 33. Мөрний хэмжилт хийх арга



Мөрний хэмжээс нь тодорхой цаг үе, газар орон дээр ямар зүйлийн амьтан байсныг тодорхойлно. Бодгаль амьтны хувьд мөрний урт, өргөнийг хэмжинэ. Уртыг өлмийний хамгийн урд хэсгээс өсгийний хамгийн сүүлчийн цэг хүртэл хэмжинэ. Хумсны урт нь амьтны хөдөлгөөний хэлбэртэй холбоотойгоор өөрчлөгдөж байдаг учраас хэмждэггүй. Өргөнийг уртын эсрэг чиглэлд хэмжинэ. Бугын мөрөн дээр гүйлтийн дагуух урд хөлийн мөрөөс дундаж шугам хүртэлх зай, дундаж шугамаас урд хөл хүртэлх зайг хэмжинэ.


Замналын мониторинг судалгаа: Замналын судалгаагаар цуглуулах үндсэн мэдээ хэрэглэхүүн нь бүс нутагт тархан байршиж буй хөхтөн амьтад болон шувуудын биологи, экологийн мэдээлэл, тэдгээртэй зэрэгцэн байрших айл, малын төрөл, тоо, худаг, ил задгай усны байршил гэх мэт зэрлэг амьтан, шувуудын тоо толгой, тархац, байршил нутагт нөлөөлж болохуйц бүс нутгийн нийгэм, эдийн засгийн холбогдолтой мэдээлэл байна.

Шулуун замналын арга зүйг ашиглан судалгаа хийх явцад дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Трансектийн шулуунаас хол, алс байгаа амьтдыг харах гэж их цаг алдахгүйгээр замналын дагуу ба энэ шулуунаас холгүй байгаа амьтдыг бүртгэхэд гол анхаарлаа чиглүүлнэ.
2. Амьтан ажигласан зай, өнцгийг тэмдэглэхдээ үргэхээс нь өмнө анх харагдсан цэгээр нь авна.

3. Амьтан хүртэлх зай, өнцгийг замналын шулуунаас сүрэг хүртэл буюу сүргийн төв цэг хүртэл алдаагүй хэмжиж, ажиглагчид багцаалсан тоо тавихгүй байхыг хичээх.
4. Трансектийн дагуу буюу ойр байгаа сүргүүдийн бодгалийн тоо, бүтцийг нямбай бүртгэхийг чухалчлан үзнэ

Зураг 34. Амьтан хүртэлх зайг хэмжих загвар зураг



Замналын уртыг алхам хэмжигчээр болон GPS ашиглан тодорхойлохоос гадна, замналын эхэлсэн, дууссан цэг болон амьтан ажиглагдсан цагийг нарийн тодорхой бүртгэх шаардлагатай.

Зураг 35. Замналын судалгааны нэгдсэн хүснэгт

Газрын нэр:																			
Замналын дугаар:																			
Ажиглагчийн нэр:																			
Замналын чиглэл, эхлэл төгсгөлийн солбицол:																			
Замналын нийт урт, өргөн:																			
№	Огноо	Цаг	Зүйл	Нийт	Эр	Эм	Залуу	Төл	Тод-гүй	Зай (метр)	Өнцөг	Ойролцоо тоо эсэх	Өргөрөг	Уртраг	Өндөршил (метр)	Амьдрах орчин	Зан төрх	Тайлбар	
1																			
2																			
3																			
4																			
5																			
6																			
7																			
8																			
9																			
10																			
11																			
12																			
13																			

Мах идэштэн амьтдын ул мөрийн мониторинг судалгаа: Мах идэштэн амьтад нь голдуу бартаа саад ихтэй орчныг шүтэн амьдрахын зэрэгцээ тухайн орчиндоо дасан зохицсон өнгө зүс (ивээл өнгө), зан төрх (мяраах, гэтэх, нуугдах, хэвтэх г.м)-ийн олон онцлог, чадвар сайн хөгжсөн байх тул шууд тооллогын арга (цэгэн, зурвас замналын арга г.м)-ыг дангаар хэрэглэх нь зохимжгүй байдаг.

Харин тодорхой зүйл амьтад (тухайлбал, цоохор ирвэс, саарал чоно г.м)-ын амьдрах орчиндоо үлдээсэн мөр, ялгадас, үүр оромж зэргээр нь тухайн амьтны амьдрах орчны онцлог, шилжилт хөдөлгөөн, тоо толгойн байдал (элбэг, ховор г.м)-ыг тодорхойлдог шууд бус тооцооллын аргуудыг хэрэглэж, илүү бодитой үр дүнг гарган авч болно. Иймэрхүү аргуудаар мэдээллийг системтэйгээр цуглуулж чадвал тухайн зүйл амьтны амьдрах орчны сонголт, идэвхжил, шилжилт хөдөлгөөн, зан авир, тухайн нутаг дахь хамгийн бага тоо толгойг тодорхойлж болно.

Иймээс, орон нутгийн ард иргэдээс авсан аман асуулга, өөрсдийн ажиглалт, судалгаа, үүр оромж, тухайн амьтны амьдрах орчиндоо үлдээсэн ул мөрийг ажиглан тогтоох зайлшгүй шаардлагатай юм. Учир нь амьтны мөр, хаяг,

маажсан болон самардсан ором ялгас, үүр оромж зэрэг нь тухайн амьтан байгаа эсэхийг тодорхойлогч гол үзүүлэлт бөгөөд тухайн зүйл амьтан өөрийн гэсэн шинж тэмдэг бүхий мөрөө үлдээдэг. Иймд, ямар зүйл амьтны мөр, үүр, хэвтэр, ялгас, баас болохыг таньж мэдэх чадварыг юуны түрүүнд эзэмших нь чухал.

Зураг 36. Мах идэштэн амьтдын хаягийн тодорхойлолт, код

МӨР	Хуучин	Мөр танигдах төдий (2 долоо хоногоос илүү болсон).
	Шинэ	Мөрний хэлбэр, хурц ирмэг мэдэгдэхүйц (1 долоо хоногоос бага, хэдэн өдөр болсон).
БААС	Хуучин	Ялгас хуучирч бутарсан, гадна тал нь цоохортож, хуваагдсан. Дотор тал нь хатсан (хэдэн долоо хоногоос хэдэн сар болсон).
	Шинэ	Ялгас үнэртэй, шинэ харагдана. Гадна тал нь гялалзсан, дотор тал нь шинэ (2-10 хоног болсон).
БУМБАА	Хуучин	Нар салхинд элэгдэж, бутарсан, бумбааны хэлбэр эвдэрсэн, бумбааны хонхор, орой дээр өвс ургасан (2-6 сараас өмнө хийгдсэн).
	Шинэ	Нар салхинд бага зэрэг элэгдсэн эсвэл огт элэгдээгүй. Бумбааны хурц ирмэгүүд тод харагдаж, сайн мэдэгдэх бөгөөд бумбааны хонхор, оройд өвс ургаагүй (1-4 долоо хоног).
ҮНЭРТЭН	Хуучин	Бага зэрэг үнэртэх буюу эсвэл огт үнэртэхгүй.
	Шинэ	Үнэр сайн ялгагдана.
ҮҮР НООХОЙ	Идэвхтэй	Амьтан орсон, гарсан ул мөр тодорхой хэмжээгээр илрэх бөгөөд нүхний амсарт тухайн эзэн амьтны үс ноос наалдсан байна.
	Идэвхгүй	Нүхний эргэн тойронд ул мөр мэдэгдэхгүй, нүхний амсар шороо, элсээр дүүрч, дагтаршиж, зарим тохиолдолд ургамал ургасан байна.

Шувууны уурлалт болон үржлийн амжилтын мониторинг судалгаа: Шувуу бол бусад амьтдаас өнгө зүс, дуугаараа тод ялгарч хүмүүсийн анхаарлыг амархан татдаг боловч судлаач болон мэдээлэл цуглуулж буй хүмүүсээс маш их анхаарал, харах чадвар, ой тогтоолтыг шаарддаг. Ялангуяа тэдгээрийн үүрлэлт, үржлийн амжилтын талаарх мэдээллийг цуглуулах үед дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Шувуудын үржлийн болон идэш тэжээлийн талбайг сүйтгэхээс болгоомжлох
- Шувуудыг дуурайж дуугарах үедээ үргээж цочоохыг хориглох (харь дуу гаргах)

-
- Үүрлэлтийн талбай болон өндөг дарагчид, дэгдээхэйнүүдийг үргээж болохгүй
 - Үүр, өндгийг зөөн шилжүүлж болохгүй
 - Судалгаа шинжилгээний ажлыг батлагдсан арга зүйн дагуу гүйцэтгэгж, холбогдох хууль тогтоомжийг зөрчихгүй байх

Судалгааны ажлыг эхлэхийн өмнө тухайн бүс нутаг болон сонгосон газар нутгийн шувуудын зүйлийн бүрдэл, үүрлэлтийн онцлогийн талаар гарсан судалгааны материалуудтай танилцсан байх шаардлагатай. Мөн шувуу таньж тодорхойлох бичгийг хэрхэн ашиглах, хээрийн судалгааны арга, техник, аюулгүйн дүрэмтэй танилцаж, шувууны томууны вакцинжуулалтад хамрагдсан байвал зохино.

Судалгааны хяналтын талбайг замналын дагуу шувууны үүр тохиолдсон цэг бүрд сонгож, мэдээ хэрэглэхүүнийг бүрдүүлнэ. Судалгааны явцад тааралдсан шувууны үүрүүдийг бүртгэн авч, тухайн шувуудын өндөглөхөөс эхлээд залуу шувууд үүрээ орхин нисэх хүртэлх хугацаанд сард хоёроос доошгүй удаа тэдгээрийн үүрлэлтийн онцлог, төрхийг алдагдуулалгүйгээр мониторинг хийж, хүснэгтэд тэмдэглэнэ. Энэ материал нь тухайн газар нутгийн шувуудын үүрлэлт болоод үржлийн амжилтын суурь мэдээлэл болох учраас зааврын дагуу үнэн зөв бөглөх нь чухал юм.

Талбай сонголт. Шувууны үүрлэлт, үржлийн амжилтын мэдээлэл цуглуулахаас өмнө тухайн бүс нутагт нэн ховор болоод ховор зүйл байгаа эсэх, ямар зүйлийг төлөөлүүлэн авч үзэх зэргийг онцгойлон анхаарч тогтоох хэрэгтэй.

47	U (Уран)	30	47.2	36.7	44.4	34.2	37	26.2	23.5
48	V (Ванади)		<10	<10	<10	<10	<10	<10	<10
49	Y (Иттри)		0.201	0.14	0.158	0.09	0.12	0.415	0.09
50	Yb (Иттерби)		0.003	0.003	0.002	0.002	0.003	0.002	0.001
51	W (Вольфрам)		0.07	0.22	0.09	0.17	0.24	0.05	0.47
52	Zn (Цайр)	5000	<5	66	114	75	17	<5	27
53	Zr (Циркони)		0.23	0.27	0.2	0.28	0.25	0.07	0.15

Кэмпийн нэгдсэн гал тогооны унд ахуйд хэрэглэж байгаа худаг усны бичил элементүүдийг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарттай харьцуулахад Уурын зуухны худаг, усан сан, гал тогоонд хэрэглэж байгаа усанд хүнцэл болон ураны агууламж стандартаас давсан, харин 14-р худгийн усанд уг 2 үзүүлэлт стандартын хэмжээн дотор байна.

Хүснэгт 56 Уурхайн унд, ахуйн усны бичил амь судлалын үзүүлэлт /9 сар/

Сорьцын нэр	Сорьцод тооцогдох хэмжээ				
	1 мл	100 мл			
	ННТ	ГБС	ГБЭТББ	СЗА	Псевдомонасаерогиноза
Кэмпийн ундны усны худаг	0	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
14-р худаг	75	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
13-р худаг	105	илрээгүй	илэрсэн	илрээгүй	илрээгүй

Авто машин цэнэглэдэг худаг	150	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
MNS 0900:2018 (ЗДА)	<100	0	0	0	0

Тайлбар: ННТ-нийт нянгийн тоо, ГБС-гэдэсний бүлгийн савханцар

ГБЭТББ- гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бичил биетэн, СЗА-сульфид задлагч агааргүйтэн

Хүснэгт 57 Уурхайн унд, ахуйн усны бичил амь судлалын үзүүлэлт /10 сар/

Сорьцын нэр	Сорьцод тооцогдох хэмжээ				
	1 мл	100 мл			
	ННТ	ГБС	ГБЭТББ	СЗА	Псевдомонасаерогиноза
Кэмгийн ундны усны худаг	0	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
14-р худаг	300	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
Кэмгийн гал тогооны оролт	95	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
Кэмгийн гал тогооны гаралт	0	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
Кэмгийн гал тогооны нөөцийн сан	95	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
13-р худаг	90	илрээгүй	илэрсэн	илрээгүй	илрээгүй
MNS 0900:2018 (ЗДА)	<100	0	0	0	0


Тайлбар: ННТ-нийт нянгийн тоо, ГБС-гэдэсний бүлгийн савханцар

ГБЭТББ- гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бичил биетэн, СЗА-сульфид задлагч агааргүйтэн

Бичил амь судлалын шинжилгээгээр нийт гэдэсний савханцрын бүлгийн бактери, халуунд тэсвэртэй гэдэсний савханцрын бүлгийн бактери, *E.coli* болон *Salmonella* /гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян/ илрээгүй, харин зарим тохиолдолд нийт нянгийн тоо стандартаас давж илрэх хандлагатай байна.


3. Уурхайн усалгаа болон бусад үст цэг

Хүснэгт 58 Уурхайн ногоон байгууламжийн худаг (1-р худаг, 9-р усан сан)


Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			05/IX	03/X
	Ө -	pH	7.99	8.23

	45°52'29.43"	EC ($\mu\text{S}/\text{cm}$)	1718	1719
	У- 106°59'48.28"	TDS (ppm)	1031	1032
		t°C	16.6	14.5
		Turbidity (NTU)	0.98	3.74


Хүснэгт 59 Малчны худаг (гар худаг, Ажирхай)

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			05/IX	03/Х
	Ө - 45°52'42.42"	pH	7.56	7.70
		EC ($\mu\text{S}/\text{cm}$)	1465	1478
	У- 106°58'29.20"	TDS (ppm)	1031	886
		t°C	14.9	12.3
	Turbidity (NTU)	0.98	2.82	

Хүснэгт 60 Байгаль орчны мониторингийн цооног (БО-1)

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			05/IX	03/Х
	Ө - 45°51'7.19"	pH	7.76	7.73
		EC ($\mu\text{S}/\text{cm}$)	962	990
	У- 106°59'22.81"	TDS (ppm)	577	594
		t°C	17.9	15.2
	Turbidity (NTU)	2.28	3.62	

Хүснэгт 61 Байгаль орчны мониторингийн цооног (БО-2)

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			05/IX	03/Х
	Ө - 45°51'5.20"	pH	7.62	7.80
		EC ($\mu\text{S}/\text{cm}$)	1077	1104
	У- 106°59'19.41"	TDS (ppm)	646	662
		t°C	18.1	15.2
	Turbidity (NTU)	2.96	2.10	

Уурхайн усалгаанд зориулсан худаг болон хяналт, мониторингийн цооногуудын усны газар дээр нь хийсэн хэмжилтээр бүгд өнгөгүй тунгалаг (булингаршил 0.98-3.74 NTU), эрдэс давс харьцангуй багатай (EC: 962-1718 $\mu\text{S}/\text{cm}$, TDS: 577-1031 ppm), саармаг орчинтой (pH 7.62-8.23) устай байна.

**Хүснэгт 62 Уурхайн усалгаа болон мониторингийн усны химийн шинжилгээ,
мг/л**

Харьцуулах стандарт	Нийт эрдэжилт хатуулаг	МГ-ЭКВ/Л	Бохирдол			Индекс	Үндсэн элементүүд					
			ПИЧ	NH ₄ ⁺	NO ₂ / NO ₃		CO ₃ ⁻ / HCO ₃ ⁻	Cl ⁻	SO ₄ ²⁻	Na ⁺	Ca ²⁺	Mg ²⁺
MNS 0900:2018	1000.0	7.00	10.0	1.5	1.0 /50.0		-	350	500	200	100	30
Уурхайн ногоон байгууламжийн худаг												
IX/06	1392.9	5.27	2.24	0.6	0.0/14 0	X ^{NaI}	18/372.1	183.9	385.0	340.8	36.5	42.0
X/04	1261.4	4.95	2.72	0.6	0.0/16 0	X ^{NaI}	18/372.1	185.7	290.0	304.5	36.1	38.3
Малчны худаг (Ажирхай)												
IX/06	1249.2	5.88	6.88	0.7	0.0/26 0	SC ^{NaI}	0/396.5	124.3	345.0	268.8	41.7	46.2
X/04	1118.0	5.34	4.16	0.3	0.0/45.0	X ^{NaI}	0/384.3	130.3	240.0	237.8	38.9	41.3
БО-ны мониторингийн цооног (№1)												
IX/06	706.5	4.66	4.32	0.1	0.8/24 0	X ^{NaII}	6/244.0	83.1	150.0	124.3	44.7	29.5
X/04	740.8	4.80	4.64	0.1	0.2/30 0	C ^{NaII}	0/286.7	92.3	125.0	129.0	46.1	30.4
БО-ны мониторингийн цооног (№2)												
IX/06	902.1	7.11	3.84	0.3	0.9/0.4	C ^{NaII}	0/184.3	93.7	181.0	129.0	66.1	46.1
X/03	848.6	6.55	3.36	0.3	0.5/0.4	C ^{NaII}	6/372.1	99.8	140.0	126.0	61.1	42.6

Уурхайн ногоон байгууламжид хэрэглэж байгаа 1-р худаг болон Ажирхай нэртэй малчны худгийн усны шинжилгээний дүнгээс химийн бүрэлдэхүүний хувьд анионуудаас давамгайлсан ионгүй холимог, катионуудаас натрийн ион дангаараа давамгайлж, 1-р төрлийн устай байна. Чанарын хувьд давсархаг (эрдэжилт 1118-1393 мг/л), ихэнхдээ хатуувтар (хатуулаг 4.95-5.88 мг-экв/л, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон бөгөөд стандартаас давсан) устай байна. Харин Байгаль орчны мониторингийн цооногийн хувьд анионуудаас ихэнхдээ гидрокарбонатын ион давамгайлсан, анионы харьцаа HCO₃⁻>SO₄²⁻>Cl⁻, катионуудаас натрийн ион давамгайлж, катионы харьцаа Na⁺+K⁺>Mg²⁺>Ca²⁺, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү (эрдэжилт 706-902 мг/л), 1-р цооногийн ус зөөлөвтөр (хатуулаг 4.66-4.80 мг-экв/л), 2-р цооногийн ус хатуувтараас хатуу (хатуулаг 6.55-7.11 мг-экв/л) устай байна. Уурхайн ногоон байгууламжид хэрэглэж байгаа 1-р худаг (9-р усан сан)-ийн усны усалгааны коэффициентийг бодож тооцоолоход K_a-3.9 гарч байгаа

23	La (Лантан)		0.07	0.03	0.09	0.02	<0.01	0.03	0.02	0.07
24	Lu (Лютеци)		<0.00 2	<0.00 2	<0.002	<0.002	<0.002	<0.00 2	<0.002	<0.002
25	Mn (Манган)	100	9	<5	<5	<5	<5	<5	188	<5
26	Mo (Анзан)	70	31.5	29.6	27.3	23.9	8.4	7.8	16.5	17
27	Nb (Ниоби)		<0.00 5	0.033	<0.005	<0.005	<0.005	<0.00 5	<0.005	<0.005
28	Nd (Неодим)		<0.01	<0.01	0.03	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
29	Ni (Диц)	20	<0.3	0.8	<0.3	1	<0.3	1.6	<0.3	4.4
30	P (фосфор)	1142	<50	76	88	155	<50	<50	76	<50
31	Pb (Хар тугалга)	10	<0.5	<0.5	<0.5	<0.5	92.9	50	38	32
32	Pr (Празеодим)		<0.00 6	<0.00 6	0.006	<0.006	<0.006	<0.00 6	<0.006	<0.006
33	Rb (Рубиди)		1.35	1.48	0.8	0.54	0.45	0.44	0.69	0.58
34	Sb (Хэврэг цагаан)	20	<0.2	<0.2	<0.2	<0.2	<0.2	<0.2	0.3	0.5
35	Sc (Сканди)		4	5	5	6	5	7	5	6
36	Se (Селен)	40	1.35	14	0.8	12.8	0.45	16.6	0.69	8.3
37	Sm (Самари)		<0.00 2	<0.00 2	0.006	0.003	<0.002	<0.00 2	<0.002	0.002
38	Sn (Цагаантугалга)		<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	0.4
39	Sr (Стронци)	2000	1067	1067	1225	1140	916	1041	1400	1405
40	Ta (Тантал)		0.014	0.047	<0.001	0.026	<0.001	0.016	<0.001	0.032
41	Tb (Терби)		<0.00 2	<0.00 2	<0.002	<0.002	<0.002	<0.00 2	<0.002	<0.002
42	Te (Теллур)		<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1
43	Th (Тори)		0.151	0.129	0.063	0.07	<0.002	0.006	<0.002	0.044
44	Ti (Титан)		<10	<10	<10	<10	<10	<10	<10	<10
45	Tl (Талли)		<0.00 7	<0.00 7	<0.007	<0.007	<0.007	<0.00 7	0.014	<0.007
46	Tm (Тули)		<0.00 1	<0.00 1	<0.001	<0.001	<0.001	<0.00 1	<0.001	<0.001
47	U (Уран)	30	40.3	33.2	29.3	23.8	14.2	14.4	20.1	19.8
48	V (Ванади)		<10	<10	<10	<10	<10	<10	<10	<10
49	Y (Иттри)		0.148	0.09	0.129	0.06	0.043	0.09	0.05	0.18
50	Yb		<0.00	<0.00	0.004	0.002	0.002	0.001	0.001	0.001


	(Иттерби)		1	1						
51	W (Вольфрам)		0.06	0.19	<0.05	0.16	0.07	0.18	0.2	0.36
52	Zn (Цайр)	5000	44	103	22	48	12	<5	<5	<5
53	Zr (Циркони)		0.16	0.4	0.27	0.24	<0.05	0.14	0.07	0.22

Уурхайн ногоон байгууламжид хэрэглэж байгаа худаг, Ажирхайн худаг болон Байгаль орчны мониторингийн 2 цооногийн усны бичил элементүүдийг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарттай харьцуулахад 1-р худгийн усанд ураны агууламж, БО мониторингийн 2 цооногийн усанд хар тугалганы агууламж 3-9 дахин, БО 1-р цооногийн усанд хүнцлийн агууламж 2.5 дахин тус тус давсан үзүүлэлттэй байна.

4. Уурхайн Цэвэрлэх байгууламжийн ус

Уурхайн Цэвэрлэх байгууламжаас гарсан усыг тусгай хоолойгоор хаягдлын сан руу шахаж хуримтлуулаад соруулдаг байна. Бид бохир усны сорьцыг умард өргөрөгийн 45°52'17.81", дорнод уртрагийн 107°0'4.24" солбицолд авсан ба шинжилгээг БОХЗТЛ-т хийлгэсэн. Бохир усыг Дундговь аймагтай гэрээ байгуулж, туслан гүйцэтгэгч компани гэрээний дагуу ирж бохирыг соруулж, оны эцэст тайлан тооцоогоо хийдэг.

Хүснэгт 64 Уурхайн Цэвэрлэх байгууламжийн хаягдал ус (Ахуйн бохир ус)

Фото зураг	Үзүүлэлтүүд	MNS 6561:2015	Шинжилгээний дүн	
			05/IX	03/X
	pH	6-9		7.28
	Жинлэгдэх бодис (мг/л)	400	96.5	82.0
	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч-XXX (мг/л)	800	382	392
	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч-БХХ ₅ (мг/л)	400	145	243
	NH ₄ -N (мг/л)	15	72.4	35.51
	NO ₂ -N (мг/л)	-	0.013	0.048
	NO ₃ -N (мг/л)	-	0.55	0.35

	N _{нийт} (мг/л)	30	72.96	35.91
	P _{нийт} (мг/л)	5	9.374	7.459

Уурхайн Цэвэрлэх байгууламжийн хаягдал усны шинжилгээний дүнгээс харахад бохирдлын үзүүлэлтүүдээс аммони, нийт азот, нийт фосфорын хэмжээ “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 6561:2015 стандартаас давсан бохирдолттой байна. Харин “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандарттай харьцуулахад бохирдлын шинжилсэн бүх үзүүлэлт нь уг стандартаас олон дахин давсан байгаа учир тогтмол соруулж, орчныг ариутгаж байх шаардлагатай.

5. Дүгнэлт

“Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт хэрэгжүүлж буй “Салхитын алт-мөнгөний үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд Усны чиглэлээр газар дээр нь 2 удаа очиж, сорьц материал цуглуулж, дүн шинжилгээг хийлээ.

Уг орд нь баяжуулах 2 үйлдвэртэй. Үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа усны чанарыг дараах байдлаар ангилан, тус тусын стандарт нормуудтай харьцуулан үнэлэв. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэглээний
- Ажиллагсдын унд-ахуйн хэрэглээний
- Ногоон байгууламжийн, малчны худаг болон БО-ны мониторингийн цооногууд
- Цэвэрлэх байгууламжийн хаягдал ус гэсэн чиглэлээр авч үзлээ.

Баяжуулах үйлдвэрийн технологийн ус:

Баяжуулах үйлдвэр-1-ийг “Аглаг Хангайн уулс” ХХК, Баяжуулах үйлдвэр-2-ийг “Соёолон” ХХК тус тус хариуцан үйл ажиллагаа явуулж байна. 1-р үйлдвэрийн технологид 3 болон 7-р усан сангаас ус төвлөрүүлэн үйлдвэрийн дэргэдэх 2-р усан сангаар дамжуулан үйлдвэрийн технологидоо хэрэглэдэг бол 2-р үйлдвэр нь нэгдсэн 1-р усан сангаар дамжуулан үйлдвэрийн дэргэдэх 6-р усан санд усаа татдаг бөгөөд 4, 5, 8-р усан сангаас 1-р усан санд усаа төвлөрүүлэн татдаг. 2 үйлдвэр хоёулаа үйлдвэрийн далангийн усыг тунгааж эргүүлэн ашигладаг. Түүнчлэн 15-17 км зайтай газарт шинээр гаргасан 2 худгаас 20 тн-ын багтаамжтай емкост бүхий авто цистернээр тус 2 үйлдвэр усаа зөөвөрлөж ахуйд болон технологид хэрэглэдэг байна.

Баяжуулах үйлдвэрүүдийн технологид хэрэглэж байгаа ус нь ихэвчлэн хлор-сульфат-натри зонхилсон найрлагатай, давстай, маш хатуу устай байна. Баяжуулах үйлдвэрийн Эргэлтийн болон Хаягдлын сангийн усыг MNS 6148:2010 стандарттай харьцуулахад бохирдлын үзүүлэлт нь стандартаас даваагүй ч эрдэс ихтэй, хлор болон сульфатын ионы хэмжээ 2-3 дахин их, бичил элементүүдээс манган (Mn), анзан (Mo), Хэврэг цагаан (Sb), селен (Se) зэрэг үзүүлэлтүүд дээрх стандартаас олон дахин давсны гадна Хүнцэл (As), Цези (Cs), Рубиди (Rb),

Стронци (Sr), Тори (Th), Талли (Tl), Вольфрам (W) зэрэг элементүүд харьцангуй өндөр агууламжтай илэрч байна.

Унд, ахуйн хэрэглээний ус:

"Аглаг Хангайн уулс" ХХК-ний ахуйн хэрэглээнд аль уст цэгээс цэнэглэж байгаагаас хамаараад харилцан адилгүй чанар, найрлагтай, ихэнхдээ эрдэсдэг, хатуу устай байна. Кэмпийн нэгдсэн гал тогооны ус нь холимог ангийн, натрийн бүлгийн, давсархаг (эрдэсжилт 1398-1403 мг/л), зөөлөвтөрөөс хатуу (хатуулаг 4.87-7.30 мг-экв/л, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон бөгөөд стандартаас давсан) устай байна.

2024 онд шинээр гаргасан 14-р худгийн хувьд сульфат-хлорын ангийн, натрийн бүлгийн, давсархаг (эрдэсжилт 1997-2161 мг/л), маш хатуу (хатуулаг 17.30-18.24 мг-экв/л) устай байна.

Уурхайн кэмпийн ундны зориулалттай худаг, усны шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангахгүй, ялангуяа 14-р худгийн усыг унд, ахуйд хэрэглэхэд тохирохгүй устай байна. Кэмпийн нэгдсэн гал тогооны унд ахуйд хэрэглэж байгаа худаг усны бичил элементүүдийг MNS 0900:2018 стандарттай харьцуулахад Уурын зуухны худаг, усан сан, гал тогоонд хэрэглэж байгаа усанд **хүнцэл болон ураны агууламж стандартаас давсан**, харин 14-р худгийн усанд уг 2 үзүүлэлт стандартын хэмжээн дотор байна.

Бичил амь судлалын шинжилгээгээр нийт гэдэсний савханцрын бүлгийн бактери, халуунд тэсвэртэй гэдэсний савханцрын бүлгийн бактери, *E.coli* болон *Salmonella* /гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян/ илрээгүй, харин зарим тохиолдолд нийт нянгийн тоо стандартаас давж илрэх хандлагатай байна.

Ногоон байгууламжид хэрэглэж буй ус болон малчны худгийн ус:

Уурхайн ногоон байгууламжид хэрэглэж байгаа 1-р худаг болон Ажирхай нэртэй малчны худгийн ус нь холимог ангийн, натрийн бүлгийн, давсархаг (эрдэсжилт 1118-1393 мг/л), ихэнхдээ хатуувтар (хатуулаг 4.95-5.88 мг-экв/л, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон бөгөөд стандартаас давсан) устай байна. Уурхайн ногоон байгууламжид хэрэглэж байгаа 1-р худаг (9-р усан сан)-ийн усанд **ураны агууламж MNS 0900:2018** стандартаас давж илэрсэн ба усалгааны коэффициентийг бодож тооцоолоход $K_a=3.9$ гарч байгаа нь усалгаанд хэрэглэхэд төдийлэн тохиромжтой биш үзүүлэлт боловч бусад хортой давсны нөлөөлөл харьцангуй бага байна.

Байгаль орчны мониторингийн цооног

Байгаль орчны мониторингийн цооногийн ус нь ихэнхдээ гидрокарбонат-натрийн ион давамгайлсан, цэнгэгдүү (эрдэсжилт 706-902 мг/л), 1-р цооногийн ус зөөлөвтөр (хатуулаг 4.66-4.80 мг-экв/л), 2-р цооногийн ус хатуувтараас хатуу (хатуулаг 6.55-7.11 мг-экв/л) устай байна. 2 цооногийн усны бичил элементүүдийг *MNS 0900:2018* стандарттай харьцуулахад 2 цооногийн усанд **хар тугалганы** агууламж 3-9 дахин, БО 1-р цооногийн усанд хүнцлийн агууламж 2.5 дахин тус тус давсан үзүүлэлттэй байна.

Ахуйн бохир ус

Кэмпийн ахуйн бохир усыг Дундговь аймагтай гэрээ байгуулж, туслан гүйцэтгэгч компани гэрээний дагуу ирж бохирыг соруулж, оны эцэст тайлангаа өгдөг.

Ахуйн бохир хаягдал усны шинжилгээгээр аммони, нийт азот, нийт фосфорын хэмжээ *“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага”* MNS 6561:2015 стандартаас давсан бохирдолттой байна. Уг усны бохирдлын бүх үзүүлэлт нь *“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”* MNS 4943:2015 стандартаас олон дахин давсан байгаа учир тогтмол соруулж, орчныг ариутгаж байх шаардлагатай.

6. Зөвлөмж

Баяжуулах үйлдвэрийн технологид хэрэглэж байсан хуучин худгуудын ус нь ихэнхдээ шавхагдаж, усгүй болсны улмаас сүүлийн жилүүдэд шинээр олон худаг гаргасан байна. Иймд хэрэглээний усны нөөцөө Усны нөөцийн зөвлөлөөр баталгаажуулахыг зөвлөж байна.

Кэмпийн нэгдсэн гал тогоонд хэрэглэж буй ундны усанд олон үзүүлэлт стандартын шаардлага хангахгүй байгаа учир “Мембран шүүлтүүр бүхий төхөөрөмж” суурилуулж усны чанарыг сайжруулж хэрэглэх хэрэгтэй.

Ахуйн хаягдал бохир усыг хуримтлуулж байгаа цөөрмийн ёроолд плёнк дэвсэх гэх мэт арга хэмжээ авч орчныг бохирдуулах, хөрсөнд нэвчих эрсдэлийг бууруулах хэрэгтэй.

БҮЛЭГ 10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
1	Цөлжилтийг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ан амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах талаар сум орон нутгийн байгууллагуудтай зөвшилцөн төлөвлөж ажиллана.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан байгаль хамгаалах ажлыг зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан байгаль хамгаалах ажлыг зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн.
2	Дундговь аймгийн “Бага газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг менежментийг төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх ажлыг компанийн зүгээс санхүүгийн асуудлыг	“Бага газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг менежментийг төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх ажлыг компанийн зүгээс санхүүгийн асуудлыг	14'800'000	Дундговь аймгийн сонгогдсон Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Уг үүрэг даалгаврын дагуу Байгаль орчны чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудад төлөвлөн худалдан авалтын төлөвлөгөө, 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж батлуулсан ажил болно.

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
		шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэн ажиллана.		<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас эрх авсан мэргэжлийн байгууллага болох “Биологийн нөөцийг хамгаалах төв” ТББ-аар хийж гүйцэтгүүлсэн.</p> <p>Загийн ус БНГ, Дэлгэрхангай уулын БНГ, Бага газрын чулуу БДГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд нутгийн иргэд, тусгай хамгаалалттай газрын ойр орчимд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага болон холбогдох засаг захиргааны албан тушаалтнуудыг оролцуулан Бага газрын чулуу БДГ-ыг Дэлгэрцогт сумын төвд 2024 оны 8-р сарын 6-нд, Дэлгэрхангай уулын БНГ-ыг Дэлгэрхангай сумын төвд 2024 оны 8-р сарын 7-нд, Загийн ус БНГ-ыг Өлзийт сумын төвд 2024 оны 8-р сарын 8-нд тус бүр хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан үр дүн, суурь мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн А/16 тоот тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалтай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй”-н дагуу ТХГ бүрээр боловсруулан, Дундговь Аймгийн Байгаль Орчны газар гэрээний хугацаанд</p>

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
				хүлээлгэн өгсөн.
3	<p>Нөлөөллийн бүсийн оршин суугчдад уурхайн үйл ажиллагааг цаг үеийн байдалтай уялдуулан орон нутгийн албан ёсны цахим хаягаар танилцуулах иргэдийг мэдээллээр сайтар хангах, www.erdenesgold.mn, компанийн пэйж хуудсаар болон орон нутгийн фэйсбүүк группүүдээр дамжуулан</p>	<p>Байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлж буй цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрт мэдээлэл бэлтгэж цахимаар танилцуулан ажиллана.</p>	100'000	<p>“Эрдэнэс алт ресурс” ХХК-ний вэб сайтаар нийт 2024 онд байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тухай бүр сурталчилж ажилласан. Нийт 14 удаагийн мэдээлэл оруулж ажилласан.</p>

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
4	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг тендер шалгаруулж гүйцэтгүүлнэ.	19'100'000	2024 онд Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар дахин хийж гүйцэтгүүлсэн. Байгаль орчны аудитын нэгтгэл, нийцэл, гүйцэтгэлийн үр дүнгийн хэрэгжилтийг үзэхэд хяналтын 94 шалгуур үзүүлэлтийн нийцэл 90.8 %, үл нийцэл 9.2%-тай байна гэсэн дүгнэлт гарсан. Байгаль орчны аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Салхит уурхай руу хүргүүлж, зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэх ажлуудыг тодорхойлсон. Ажлын гүйцэтгэлийг гэрээ дүгнэсэн актаар хүлээж авсан.
5	Цөлжилтийг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ан амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах талаар сум орон нутгийн байгууллагуудтай зөвшилцөн төлөвлөж ажиллана.	Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Компанийн нийгмийн хариуцлагын дагуу “Дундговио ногооруулья” дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ төлөвлөж, үр дүн гарган ажиллах	Өөр бүлэгт зардал тооцогдсон.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 50000 ширхэг хайлаас мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд нийт 2000 ширхэг 3-5 настай шинэс модны суулгацыг

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
				<p>тарих ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа. “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 20000 ширхэг хайлаас модны суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд 20000 ширхэг модыг Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д нэмэлтээр тарилаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 75555 модыг тарьсан.</p> <p>“Тэрбум мод” санаачилгын хүрээнд Богдхан уулын дархан цаазат газарт мод тарих ажлын гэрээг “Эрдэнэс алт ресурс” ХХК Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж, тус гэрээг БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ баталгаажуулсан.</p> <p>Уг гэрээний хүрээнд “Эрдэнэс алт ресурс” ХХК Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд 5000 мод тарьж арчилж</p>

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
				ургуулахаар зөвшилцөн төлөвлөн ажиллаж байна.
			34'000'000	



Дундговь аймгийн сонгогдсон Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Уг үүрэг даалгаврын дагуу Байгаль орчны чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудад төлөвлөн худалдан авалтын төлөвлөгөө, 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж батлуулсан ажил болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас эрх авсан мэргэжлийн байгууллага болох “Биологийн нөөцийг хамгаалах төв” ТББ-аар хийж гүйцэтгүүлсэн.

Загийн ус БНГ, Дэлгэрхангай уулын БНГ, Бага газрын чулуу БДГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд нутгийн иргэд, тусгай хамгаалалттай газрын ойр орчимд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага болон холбогдох засаг захиргааны албан тушаалтнуудыг оролцуулан Бага газрын чулуу БДГ-ыг Дэлгэрцогт сумын төвд 2024 оны 8-р сарын 6-нд, Дэлгэрхангай уулын БНГ-ыг Дэлгэрхангай сумын төвд 2024 оны

8-р сарын 7-нд, Загийн ус БНГ-ыг Өлзийт сумын төвд 2024 оны 8-р сарын 8-нд тус бүр хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан үр дүн, суурь мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн А/16 тоот тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалтай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй”-н дагуу ТХГ бүрээр боловсруулан, Дундговь Аймгийн Байгаль Орчны газар гэрээний хугацаанд хүлээлгэн өгсөн.

БҮЛЭГ.11 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн иргэдийн өдөрлөгт оролцож мэдээлэл хүргэх эсхүл орон нутгийн албан ёсны цахим хаягаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангах	200'000	Байгаль орчны хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үйл ажиллагааны танилцуулга мэдээлэл өгөх	Дундговь аймгийн Гурвансайхан сумын зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн цахим хуудсуудаар дамжуулан хийж хэрэгжүүлж буй ажлуудын талаарх мэдээллийг тогтмол хүргүүлж ажилласан. Мөн орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад хүсэлт гаргаж Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах бүрт оролцож мэдээллээр хангаж ажилласан. 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн хурлыг Салхит уурхай дээр зохион байгуулахад хамтарч, үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгч ажилласан.
2	Гурвансайхан сумын ЗДТГ, ИТХ, багийн иргэдийн	100'000	Уурхай, үйлдвэрлэлийн үйл	Үйлдвэр, уурхай, компанийн үйл ажиллагааны талаар нутгийн иргэдэд танилцуулж, сурталчлах ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэдэг бөгөөд 2024 оны

	төлөөллүүдийг уурхайн үйл ажиллагаатай танилцуулах		ажиллагааг газар дээр нь танилцуулах	07 дугаар сарын 08-ны өдөр Салхит уурхайд багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж мэдээлэл өгч ажилласан.
3	Уурхайн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны БОМТ хэрэгжилтийн тайланг ажлын хэсгийн гишүүдэд газар дээр нь танилцуулах	200'000	Уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг газар дээр нь танилцуулах	Дундговь аймгийн Засаг даргын А/420 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгах хуваарийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулж ажилласан.
4	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон 2024 оны батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах	-	Тайлан боловсруулж, төлөвлөгөөг батлуулсан байна.	<p>2024 оны батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний тайланг Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт болон Дундговь аймгийн Гурвансайхан сумын БОХУБ нарт хүргүүлсэн.</p> <p>Мөн Байгаль орчны 2024 оны аудитын үл нийцлийн тайлан, химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайлан, ус ашиглалтын тайлан, БОМТ-ний тайланг 2024 оны 12 дүгээр сарын 17-ны өдөр эцэслэн батлуулж Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Умард гүвээт дундад- халхын тал сав газрын захиргаа, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргад хүргүүлж ажилласан.</p> <p>2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг орон нутгийн ажлын хэсгээс өгсөн үүрэг</p>

				даалгаварт үндэслэн 2025 оны уулын ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсаны дараа БОУАӨЯ-аар батлуулж хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
		500'000		

БҮЛЭГ 12. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮГНЭЛТ

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Салхитын мөнгө-алтны ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсрууллаа.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож оруулсан.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, усны нөөцөд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө зэрэг хийх ажлуудыг тусгаж өгсөн.

Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас ирүүлсэн албан бичигт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тодорхой хэмжээ бүхий эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх талаар тусгасны дагуу хэрэгжилтийг ханган ажилласан.

Уурхайн явцын болон хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөлт, зураглалыг боловсруулж, 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэсэгт тусгаж 2024 онд хөрсний овоолгын налууг хэлбэржүүлэх ажилд 9.4 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Мөн 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Уурхайн хаягдал

чулуулгийн овоолгын налууд хөрс тогтворжуулах геосетка байрлуулж шинэ технологи туршиж олон наст зүлэг тарьсан. ХААИС-ийн харьяа МАА Бэлчээрийн хүрээлэнгийн генийн сангаас Сүмбэр сортын Саман ерхөг, Мандал сортын Эмзэг түрүүт өлөн, Бургалтай сортын шар царгасын үрээр ургамалжуулах ажлыг 0,5 га талбайд тарьсан. Овоолго 1-ийн налуу дээр 0.5 га талбайд ургамалжуулсан. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон, нөхөн сэргээлт хийгдэх шаардлагатай газруудын нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилготойгоор орон даяар "Нөхөн сэргээлт-2024" арга хэмжээг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж байгаа юм. Уг ажлын хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хүлээж авах ажлын хэсгийн зүгээс Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Буурал, Төмөрт, Ар цагаан гэх газруудад өнгөт чулуу хууль бус олборлолтоос эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг "Эрдэнэс алт ресурс" ХХК-д даалгасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд нийт 11 байршилд хамаарах 4,33 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн орон нутагт актаар хүлээлгэн өгсөн. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явцад Дундговь аймгийн Байгаль орчны газар, Дэлгэрцогт сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Дундговь аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн, Дэлгэрцогт сумын байгаль орчны мэргэжилтэн, Цахиурт багийн Засаг дарга, Дэлгэрцогт сумын нутгийн иргэд ажлын үе шат бүр хамтарч хяналт тавин ажилласан.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тус оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт Тарвага сэргээн нутагшуулах ажлыг хамгаалалтын захиргаатай хамтран 3 дахь жилдээ зохион байгуулж, Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах ажлын хүрээнд биотехникийн арга хэмжээ авахад шаардлагатай өвсийг худалдан авч хүлээлгэн өгөх, цаг үеийн шинж чанартай байгаль хамгаалах, тооллого судалгаа, хүн хүч, машин техникийн туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг Их газрын хамгаалалтын захиргаатай тухай бүр харилцан тохиролцож хамтран зохион байгуулж ажилласан.

Мөн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлж буй цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрт хүргэж ажиллахаар төлөвлөсөн бөгөөд Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтран ажиллах ажлын зардлаас зарцуулах тул БОМТ-ний нийт зардалд оруулж тооцоогүй болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор "Эрдэнэс алт ресурс" ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Хаврын бүх нийтээр мод

тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 50000 ширхэг хайлаас мод, Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд нийт 2000 ширхэг 3-5 настай шинэс модны суулгацыг тарих ажлыг тус тус зохион байгуулан ажиллалаа. “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2024 оны Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 20000 ширхэг хайлаас модны суулгацыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд 20000 ширхэг модыг Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д нэмэлтээр тарилаа. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 75555 модыг тарьсан.

“Тэрбум мод” санаачилгын хүрээнд Богдхан уулын дархан цаазат газарт мод тарих ажлын гэрээг “Эрдэнэс алт ресурс” ХХК Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж, тус гэрээг БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ баталгаажуулсан.

Уг гэрээний хүрээнд “Эрдэнэс алт ресурс” ХХК Богдхан уулын дархан цаазат газрын Чандманы аманд 5000 мод тарьж арчилж ургуулахаар зөвшилцөн төлөвлөн ажиллаж байна.

Хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх шаардлагатай. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдал, ахуйн хаягдлыг мэргэжлийн компанитай гэрээ байгуулан, тээвэрлэж устгах ажлыг компанийн хог хаягдал, байгаль орчны бусад журмуудын дагуу зохион байгуулж ажилласан.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Эрдэнэс алт ресурс” ХХК нь зохион байгуулж ажилласан.

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт танилцуулга хийхээр төлөвлөсөн.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **116,378,000** төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож **58,189,000** төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний

тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулж ажилласан.

“Салхитын мөнгө алтны орд” төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж тайлагнасан бөгөөд Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тайлагнаж ... %-ийн үнэлгээтэйгээр дүгнэгдсэн.

Салхитын мөнгө-алтны ордын олборлолт, уулын баяжуулах үйлдвэр, геологи эрэл хайгуулын ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшхи хугацаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны Байгаль орчныг хамгаалах ажилд **1'337'400'000** төгрөгийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 13. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА ХҮСНЭГТ

№	ЗАРДЛЫН УТГА	НИЙТ ЗАРДАЛ, ТӨГ
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	113'860'000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний ажлын зардал	500'000'000
	Нөхөн сэргээлт, Ногоон байгууламж, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	452'000'000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	131'800'000
4	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	500'000
5	Осол эрдслийн менежментийн төлөвлөгөөний зардал	500'000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	35'340'000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	68'900'000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний ажлын зардал	34'000'000

9	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	500'000
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		1'337'400'000

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа

№	Үйл ажиллагааны төрөл	Дүн(Төгрөг)
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	1'000'000
2	Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	73'460'000
3	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	500'000
4	Ургамлын аймаг, ургамлан нөмрөг үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	19'000'000
5	Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	19'900'000
НИЙТ ЗАРДАЛ		113'860'000

---oOo---

**“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТААР
 ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ 2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024.12.14

Салхит уурхай

№	Үл нийцэл болон авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд	Гүйцэтгэх хугацаа	Хүрэх үр дүн	Төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь
ХУУЛИЙН ЕРӨНХИЙ НИЙЦЭЛ					
1	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажилд нэмэлт тодотгол хийлгэх	2025 оны 2, 3 дугаар улиралд	Мэргэжлийн компаниар газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажилд нэмэлт тодотгол хийлгүүлсэн байна.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны нэмэлт тодотгол хийлгэх ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган 2025 оны 2, 3 дугаар улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	10%
2	Орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж, жил бүр гэрээг дүгнэж акт үйлдэж явах	2024, 2025 онд	Орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж, жил бүр гэрээг дүгнэж акт үйлдсэн байна.	2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Дундговь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг дүгнэж, акт үйлдсэн.	100%
УСНЫ НӨӨЦ, ЧАНАР					
3	Хүчинтэй хугацаа дуусгавар болсон усны тоолуур баталгаажуулалтын гэрчилгээнүүдийг сунгуулах	2025 оны 1, 2 дугаар улиралд	Тоолуурын бүртгэл судалгааг хийж, хугацаа дууссан гэрчилгээнүүдийг	2025 оны 1 дүгээр улиралд тоолуур болон гэрчилгээг тулган баталгаажуулах, бүртгэлжүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна.	10%

4	<p>Уурхайн төв кемпийн ахуйн хэрэглээний усны эх үүсвэрийн орчмын 50 м бүс дотор буй бохирдуулагч эх үүсвэрүүдийн (уурын зуухны үнсний сан, кемпийн саарал усны сан, уулын хүн машин механизмын зогсоол) байршлыг нүүлгэн шилжүүлэх</p>	Жилийн турш	<p>Усны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p>	<p>Уурхайн төв кемпийн хашаанд ажилчдын кемп байгуулан ажиллаж байсан туслан гүйцэтгэгч “Сидар” ХХК-ийн ажилчдын кемпийг буулгаж, ашиглагдахгүй техник, хэрэгслийг зориулалтын зогсоолын талбайд байрлуулах шаардлага тавьж байршлыг шилжүүлсэн. Халаалтын уурын зуух болон ахуйн бохир усны хаягдлын сан зэрэг нь анх байгуулахдаа уг байршилд барьж байгуулсан тул байршлыг өөрчилж дахин барьж байгуулахад их хэмжээний зардал шаардагдах тул дараа оны төсвийн төсөлд тусгаж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.</p>	50%
5	<p>Ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийн ажиллагааг сайжруулж саарал усны найрлагыг MNS 4943 : 2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагад нийцүүлсний дараа хөрсөнд зайлуулах</p>	Жилийн турш	<p>MNS 4943 : 2015 стандартыг мөрдөж, стандартын шаардлагад нийцүүлсний дараа хөрсөнд зайлуулах арга хэмжээг авч ажилласан байна.</p>	<p>Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй “Дулаан сэнтий” ХХК туслан гүйцэтгэгч компанид цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, дутагдал зөрчлийг арилгах, засвар үйлчилгээ, шаардлагатай материал, хэрэгслийг бэлэн байлгаж стандартын дагуу үйл ажиллагаа явуулах талаар албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн цэвэр болон бохир усны шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангахгүй байгаа талаар дүгнэлт тайлан ирсэн тул уг дүгнэлтийн дагуу арга хэмжээг яаралтай авч ажиллах талаар чиглэл өгч ажилласан.</p>	80%
6	<p>Флотацийн эргэлтийн усан сангийн шүүрэл нэвчилтийг хянах хяналтын худгуудыг</p>	Байнга мөрдөх	<p>Үзлэгийн хуудасыг хөтлүүлж, хяналт тавьж ажилласан байна.</p>		

	байгуулж хаягдлын сангийн үзлэгийн хуудас хөтөлж явах				
7	Баяжуулах үйлдвэрийн шингэн хаягдлын далангийн шүүрэлт, нэвчилт явагдаж буй эсэхийг хянах хяналт тавих	Жилийн турш	Хяналт мониторингийн цооногуудын аюулгүй ажиллагаанд байнгийн хяналт хийж ажилласан байна.		
8	Ахуйн бохирыг цэвэршүүлсний дараа үүсч буй саарал усны сангийн байгууламжийн байршлыг өөрчилж сайжруулах	2025	Цэвэрлэх байгууламжийн хадгалах сангийн байгууламжийг шинэчилж засвар үйлчилгээг хийж ажилласан байна.	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй “Дулаан сэнтий” ХХК туслан гүйцэтгэгч компанид цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, дутагдал зөрчлийг арилгах, засвар үйлчилгээ, шаардлагатай материал, хэрэгслийг бэлэн байлгаж стандартын дагуу үйл ажиллагаа явуулах талаар албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Дулаан сэнтий ХХК нь цэвэрлэх байгууламжтай холбоотой мэргэжлийн байгууллагад хандаж цэвэрлэх байгууламжийг стандартын дагуу засварлаж сайжруулах талаар зөвлөмж авч, шаардлагатай зардлыг тодорхойлуулах ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Мөн бага хэмжээний засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.	

9	Унд ахуйд хэрэглэж буй усны шинжилгээний дүнгээр олон удаагийн давтамжтай натри, кали тогтмол өндөр илэрч стандартаар зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрч байвал шүүгчийг сайжруулах эсхүл солих	2025	Унд ахуйн стандартаас зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрч байвал шүүгчийг сайжруулах эсхүл солих ажлыг зохион байгуулж ажилласан байна.		
ХӨРС ХАМГААЛАЛ, ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ					
10	Тос, шатахуунаар бохирдсон хөрсийг хуулж тусгаарлах материал дэвсэж засаж тохижуулсан талбайд хадгалах боломжтой тохиолдолд биологийн аргаар боловсруулалт хийх	Жилийн турш	Төвлөрсөн хогийн цэгт тос, шатахуунаар бохирдсон хөрсийг хадгалах зориулалтын талбай бэлдэх		
АГААРЫН ЧАНАР, ФИЗИК НӨЛӨӨЛӨЛ					
11	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий шийдэл ашиглах талаар төлөвлөн хэрэгжүүлж явах	Жилийн турш	Тус ажлын хэрэгжилтийг ханган ажилласан байна.		
ХОГ ХАЯГДАЛ, ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ					

12	Ахуйн хог хаягдлын цэгийг хог хаягдал салхиар тархахаас сэргийлсэн, хур тунадасны ус хуримтлагдахаас сэргийлсэн хийцтэй болгох	2025	Хур бороогоор угаагдах болон салхинд хийсч орчныг бохирдуулах нөхцлийг хязгаарлах төмөр хийц бүхий хогийн цэгийг байгуулсан байна.	Ахуйн болон аюултай хог хаягдлын цэгийн хүрээгээр үерийн уснаас хамгаалсан шуудуу татаж, хөмсөгжүүлэн өндөрлөж, ачиж тээвэрлэхэд хялбар болгож засварласан. Аюултай хогийг цэгийг тохижуулах ажлын хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Хог хаягдлын менежментийн хэсэгт тусгагдсаны дагуу тендер зарлаж “Аз металл” ХХК-иар 10х20 метрийн буюу 200 метр квадрат талбайг бетонжуулж хаягдал тос хаях цэгийг хөрсөнд нэвчихээс сэргийлж ажилласан. Мөн 25 тонны багтаамжтай хаягдал тос хуримтлуулах ёмкостыг байрлуулж бага хэмжээтэй савнуудад хуримтлуулж байсан хаягдал тосыг нэгтгэж зориулалтын саванд зөөвөрлөн хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
13	Ажилласан тосыг хүлээн авагч байгууллагад шилжүүлэхийн өмнө түр хадгалах цэгт хур тунадасны ус, хөрс шороотой холилдохгүй нөхцөлд битүү саванд хийж хадгалах	2024	Зөвлөмжийн дагуу хуримтлагдсан ажилласан тос, техникийн шингэнийг тусгай зориулалтын талбайд зөөвөрлөн шилжүүлэн хурааж, улмаар хоёрдогч байгууллагад тушаах ажлыг зохион байгуулж ажилласан байна.	Хог хаягдлын менежментийн хэсэгт тусгагдсаны дагуу тендер зарлаж “Аз металл” ХХК-иар 10х20 метрийн буюу 200 метр квадрат талбайг бетонжуулж хаягдал тос хаях цэгийг хөрсөнд нэвчихээс сэргийлж ажилласан. 25 тонн хаягдал тос хуримтлуулах ёмкостыг байрлуулж бага хэмжээтэй савнуудад хуримтлуулж байсан хаягдал тосыг нэгтгэж зориулалтын саванд зөөвөрлөн хийж ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
14	Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлан маягт хөтөлж явах	Жилийн турш	Хоёрдогч байгууллагад тушаах ажлыг	Эрдэнэс алт ресурс ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/136 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны	100%

			<p>зохион байгуулж ажилласан байна.</p>	<p>журмуудын хүрээнд үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлыг хавсралт маягтын дагуу тоон мэдээллийг сар, улирал, бүтэн жилээр гаргаж нэгдсэн тоон мэдээллийг нэгтгэж ажиллаж байна. Жилийн эцэст нэгтгэсэн тоон мэдээллийг БОХ маягтын дагуу Дундговь аймгийн Байгаль орчны газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилладаг.</p> <p>Баяжуулах 1, 2 дугаар үйлдвэрүүдээс гарч буй химийн бодисын сав баглаа боодол, Химийн лаборатори болон бусад үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлууд:</p> <ul style="list-style-type: none"> • Баяжмалын цамц -8540 кг • бодисын шуудай 993кг+2755 кг=3748 кг • химийн бодисын бочка 99 ширхэг, • хаягдал ажилласан тос 13000 кг • Лабораторийн аюултай хог хаягдал: 15700 кг <p>2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Салхит уурхайн үйл ажиллагаанаас нийт 40988 кг аюултай хог хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК, Элемент ХХК, “Ариун хими” ХХК зэрэг мэргэжлийн байгууллагуудад гэрээний дагуу нийлүүлж устгуулсан.</p>	
- 3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.
- 3.10. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасны дагуу “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасан тул Хүлээн авагч нь тухай бүр и-баримтыг бүртгэсэн байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
 - 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 2 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө бичгийг буцаан авна.
 - 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
 - 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах харилцан тохиролцож шилжүүлнэ.
 - 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
 - 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлсэнээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
 - 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
 - 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах
 - 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.

- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авсанаас хойшхи түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 4.2.8 Хүлээн авагч нь “Салхит мөнгө алтны уурхайн” бүсэд ажиллаж байхдаа захиалагч болон бусад этгээдэд эдийн ба эдийн бус хохирол учруулсан тохиолдолд дангаар хохирлыг барагдуулж хариуцлага хүлээх болно.
- 4.2.9 “Салхит мөнгө алтны уурхайн”-н бүсэд дагаж мөрдөгдөх аливаа дүрэм журмыг чанд сахин мөрдөн ажиллах үүрэгтэй.
- 4.2.10 “Салхит мөнгө алтны уурхайн”-н бүсэд шинээр очин ажиллаж байгаа ажилчид нь ХАБ-ын анхан болон давтан зааварчилгаанд хамрагдаж ХАБ-ын мэргэжилтнээс өгсөн зааврын дагуу ажлаа хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.2.11 Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг стандартын дагуу хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хийх ба Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг хариуцах үүрэгтэй.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р багийн нутаг дэвсгэрт орших “ТҮМЭН ЭГШИГ ХХК БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.
- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

Зургаа. Өмчлөх эрх шилжих

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн

- дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
 - 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
 - 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
 - 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
 - 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.


Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойшхи эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл


- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:
 Ерөнхий менежер
 / Ч.Баяртөр /
 Хуулийн мэргэжилтэн
 / М.Заяа /

Суурин утас: 70005292
 Регистер: 5644984

Хаяг УБ, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, 13 хороолол, манлайбаатар дамдинсүрэн, Ю-Би тауэр 83/2 1601 тоот

Хүлээн авагч талыг төлөөлж:
 ТҮМЭН ЭГШИГ ХХК-ийн
 ЕРӨНХИЙ МЕНЕЖЭР
 / Б.Одбаяр /

Суурин утас: 77110428
 Гар утас: 92050001, 88990428
 Регистер: 5031923

УБ гэрчилгээний дугаар:
 Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001
 Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
 Намъянжугийн – 44, Түмэн эгшиг ХХК-ийн, өөрийнбайр

“Түмэн эгшиг” ХХК, “Соёолон интернэшнл” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
12/05 тоот гэрээний Хавсралт № 01



2022-2023 онд СОЁОЛОН ИНТЕРНЭШНЛ ХХК-ИЙ ЖИЛД УСТГУУЛАХ
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /			
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1						
2						

ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Үүсгэгч талыг төлөөлж:
Ерөнхий инженер

..... /Ч.Баяртөр

Суурин утас: 70005292

Регистер: 5644984

Хаяг УБ, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, 13 хороолол, манлайбаатар дамдинсүрэн, Ю-Би тауэр 83/2 1601 тоот

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хүлээн авагч талыг төлөөлж:
Түмэн эгшиг ХХК-ийн
Ерөнхий Менежер

..... /Б.Одбаяр/

Хуулийн зөвлөх

..... /Г.Алтанчимэг/

Суурин утас: 77110428

Гар утас: 99176967

Регистер: 5031923

УБ гэрчилгээний дугаар:

Тусгай зөвшөөрлийн дугаар: -000001

Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъяанжугийн – 44, Түмэн эгшиг ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: chemicalwasterisk@gmail.com

Шуудангийн хаяг: 51-салбар 499

“Түмэн эгшиг” ХХК, “Соёолон интернэшнл” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
12/05 тоот гэрээний Хавсралт № 02

**ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ**

(тээврийн зардал нөвт тооцоогүй үнэ болно)

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төг/
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л,	тн	1	1150000
2	Химийн хуванцар торх / 100л/	ш	1	4800
3	Химийн хуванцар торх /200л/	ш	1	7900
4	Химийн хуванцар ИВС танк /1000л/	ш	1	18000
5	Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/	тн	1	1250000
6	Төмөр торх боошиг	ш	1	8200
7	Химийн бодисийн шил,сав	ш	1	1500
8	Химийн хатуу хуурай хаягдал	кг	1	5600
9	Химийн хаягдал шингэн уусмал 1литр	л	1	6000
10	Хаягдал аккумулятор	ш	1	4000
11	Масло шүүр том оврийн	ш	1	3800
12	Принтер хор	ш	1	2500
13	Хаягдал агаар шүүгч филтэр	ш	1	3000
14	Хаягдал лаг	кг	1	3800
15	Хаягдал цаас бохирдсон	кг		1200
16	Хаягдал маск болон бээлий нийлэг материал	кг	1	1500
17	Хаягдал шингээгч даавуу химийн бодистой	кг	1	3500
18	Хаягдал төмөр материал болон бусад	кг	1	2500
19	Хаягдал лааз сав	ш	1	1100
20	Хаягдал баттарей	кг	1	3500
21	Ашигласан масло тос	1 литр	1	800
22	Хөргөлтийн шингэн тосол	1 литр	1	1000
23	Галын хорны баллон том жижиг/дунд	1ш	1	3500-4800
24	Бохирдсон хөрс тостой	тонн	1	1600000
25	Эмнэлгийн хаягдал	Кг	1	5500
26	Хаягдал акумулятор том	ш	1	3500
27	Хаягдал Battery	Кг	1	3800
28	Хаягдал дугуй /том/	Том/жижиг	1	12000.18000



**АЮУЛТАЙ ХОГ, ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭНИЙ
ХУГАЦАА СУНГАХ НЭМЭЛТ ГЭРЭЭ**

2024 оны 3 дугаар сарын 1-ний өдөр

№ Т/21-1

Улаанбаатар хот

Энэхүү "Аюултай хог, хаягдал тээвэрлэлтийн гэрээний хугацаа сунгах нэмэлт гэрээ" (цаашид "Нэмэлт гэрээ" гэх)-г нэг талаас

Монгол Улсын хуулийн этгээд болох Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, Дамдинсүрэнгийн гудамж, Ю-Би Тауэр 1501 тоот хаягт байрлах, Регистрийн 5644984 дугаартай "Соёолон Интернэшнл" ХХК, түүнийг төлөөлж Худалдан авалтын ахлах мэргэжилтэн Б.Номин (цаашид "Тээвэрлүүлэгч" гэх) болон

Нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжугийн -44 хаягт байрлах, Регистрийн №5031923 дугаартай "Түмэн эгшиг" ХХК, түүнийг төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр (цаашид "Тээвэрлэгч", хамтад нь "Талууд" гэх) нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцон байгуулав.

Нэг. Нэмэлт, өөрчлөлт

- 1.1 Энэхүү нэмэлт гэрээгээр талуудын хооронд байгуулагдсан 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн № Т-21/ дугаартай "Аюултай хог, хаягдал тээвэрлэлтийн гэрээ"(цаашид "Үндсэн гэрээ" гэх)-ний 2 дугаар зүйлийн 2.1-д заасан хугацааг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар (цаашид "Сунгагдсан хугацаа" гэх) сунгахаар харилцан тохиролцов.
- 1.2 Сунгагдсан хугацаанд Үндсэн гэрээний бүхий л нөхцөл хэвээр үйлчилнэ.

Хоёр. Бусад зүйл

- 2.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь талуудын хооронд байгуулагдсан Үндсэн гэрээний салшгүй хэсэг бөгөөд Нэмэлт гэрээнд өөрөөр тодорхойлсноос бусад Үндсэн гэрээний зүйл заалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 2.2. Энэхүү Нэмэлт гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Тээвэрлүүлэгч:
Соёолон интернэшнл ХХК-ийг төлөөлж
Худалдан авалтын ахлах мэргэжилтэн
Б.Номин

Тээвэрлэгч:
Түмэн эгшиг ХХК-ийг төлөөлж
Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай
Б.Одбаяр

Гарын үсэг _____

Гарын үсэг _____

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, Дамдинсүрэнгийн гудамж, Ю-Би Тауэр 1501 тоот,

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжугийн -44

Утас: 86005292
Имэйл: nomin@soyolon.mn

Утас: 99721881
Имэйл: chemicalwasterisk@gmail.com

Гүйцэтгэгчийг төлөөлж:.....

Захиалагчийг төлөөлж:.....

Батлав: “Соёолон Интернэшнл” ХХК
Санхүү хариуцсан захирал



Батлав: Түмэн эгшиг ХХК
Гүйцэтгэх захирал



**АЮУЛТАЙ ХОГ, ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ
ХУГАЦАА СУНГАХ НЭМЭЛТ ГЭРЭЭ**

2024 оны 3 дугаар сарын 1-ний өдөр

№ 12/05-1

Улаанбаатар хот

Энэхүү “Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээний хугацаа сунгах нэмэлт гэрээ” (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г нэг талаас

Монгол Улсын хуулийн этгээд болох Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, Дамдинсүрэнгийн гудамж, Ю-Би Тауэр 1501 тоот хаягт байрлах, Регистрийн 5644984 дугаартай “Соёолон Интернэшнл” ХХК, түүнийг төлөөлж Худалдан авалтын ахлах мэргэжилтэн Б.Номин (цаашид “**Үүсгэгч**” гэх) болон

Нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжугийн -44 хаягт байрлах, Регистрийн 5031923 дугаартай Түмэн эгшиг ХХК, түүнийг төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр (цаашид “**Хүлээн авагч**”, хамтад нь “**Талууд**” гэх) нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцон байгуулав.

Нэг. Нэмэлт, өөрчлөлт

- 1.1 Энэхүү Нэмэлт гэрээгээр талуудын хооронд байгуулагдсан 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн № 12/05 дугаартай “Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээ” (цаашид “Үндсэн гэрээ” гэх)-ний 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хугацааг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар сунгахаар (цаашид “Сунгагдсан хугацаа” гэх) харилцан тохиролцов.
- 1.2 Сунгагдсан хугацаанд Үндсэн гэрээний бүхий л нөхцөл хэвээр үйлчилнэ.

Хоёр. Бусад зүйл

- 2.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь талуудын хооронд байгуулагдсан Үндсэн гэрээний салшгүй хэсэг бөгөөд Нэмэлт гэрээнд өөрөөр тодорхойлсноос бусад Үндсэн гэрээний зүйл заалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 2.2. Энэхүү Нэмэлт гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Үүсгэгч:
“Соёолон Интернэшнл” ХХК-ийг төлөөлж
Худалдан авалтын ахлах мэргэжилтэн
Б.Номин

Гарын үсэг _____

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, Дамдинсүрэнгийн гудамж, Ю-Би Тауэр, 1601 тоот,

Утас: 86005292
Имэйл: nomin@soyolon.mn

Тээвэрлэгч:
“Түмэн эгшиг” ХХК-ийг төлөөлж
Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай
Б.Одбаяр

Гарын үсэг _____

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжугийн -44

Утас: 99721881
Имэйл: chemicalwasterisk@gmail.com

Гүйцэтгэгчийг төлөөлж:.....

Захиалагчийг төлөөлж:.....



ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 02 -р сарын 13, -ны өдөр

№ ХБ-24/022

08/14

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас “Элемент” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа нөгөө талаас /цаашид захиалагч гэх/-ыг “Тру Ти Ар Си” ХХК-ийг төлөөлж Чанарын Менежер З.Ариунгоо бид харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгахад оршино.
2. Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1 Захиалагч дараах эрхтэй:

- 2.1.1 Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 2.1.2 Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах.
- 2.1.3 Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2 Захиалагч дараах үүрэгтэй:

- 2.2.1 Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх.
- 2.2.2 Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах.
- 2.2.3 Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах.
- 2.2.4 Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах.
- 2.2.5 Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих.
- 2.2.6 Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх.
- 2.2.7 Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх.

- 2.2.8 Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог ачилтанд хяналт тавих тус тус үүрэгтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч дараах эрхтэй:

- 3.1.1 Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 3.1.2 Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй.
- 3.1.3 Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шоншготой, аюултай гэмдэллэгээтэй байхыг шаардах хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 3.1.4 Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй.

3.2 Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

- 3.2.1 Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, захиалагч талын хог хаягдлыг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх.
- 3.2.2 Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,
- 3.2.3 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,
- 3.2.4 Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,
- 3.2.5 Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах
- 3.2.6 Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,
- 3.2.7 Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.
- 4.2 Захиалагч аюултай хог хаягдлын устгал өгөхөөс өмнө устгалын урьдчилгаа төлбөр **500,000.0 /Таван зуун мянга/ төгрөг** гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ. Урьдчилгаа төлбөр нь нийт устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.
- 4.3 Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачил тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжлэнэ.
- 4.4 Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар устгалын акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор "Элемент" ХХК-ийн 1715164140 /Голомт банк/ тоот дансанд төлнө.
- 4.5 Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой объектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ.
- 4.6 Төлбөр тооцоог байгууллагын данснаас бусад хувь хүний дансанд шилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

- 4.7 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж гэрээг 1 жил буюу 2024 оны 02 сарын 15-ны өдрөөс 2025 оны 02-р сарын 15-ны өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Энэхүү гэрээний 4.4-т заасан хугацаанд захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.
- 5.2 Энэхүү гэрээний 4.7-д заасан хугацаанд гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувиар алданги төлнө.
- 5.3 Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дүрэм журмыг мөрдөөгүйгээс гэрээнд оролцогч талуудад гэм хор учирсан бол буруутай тал нь хариуцлагыг бүрэн хүлээнэ.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт тал түймэр, газар хөдлөлт, сахли шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорно, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэргэсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.
- 6.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүтээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.
- 6.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.4 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.
- 7.2 Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрчлэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

- 8.1 Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 8.2 Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 9.1 Талууд харилцан тохиролцооноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна.
- 9.2 Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:
- 9.2.1 Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр,
- 9.2.2 Талууд харилцан тохиролцооноор.
- 9.3 Гэрээ дараах үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлагдана. Үүнд:
- 9.3.1 Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа (2 ба түүнээс дээш удаа) биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй.
- 9.3.2 Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан зэрэг болно.

АРАВ. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА

- 10.1 Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.
- 10.2 Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно
- 10.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.
- 10.4 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.
- 10.4.1 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 10.4.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шударгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үүгээр баталж байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:
Ерөнхий менежер албан тушаалтай
Хандуур /Б.Ундармаа/ →
Утас: 83103666
Ерөнхий нягтлан бодогч албан тушаалтай
А. Энхтуяа /
Утас: 86113790
/Тамга мөхөөгч/
Харилцах утас: 8610-3790, 9910-7745
РД: 2100061
Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо, Бүс нуур /12610/

Захиалагчийг төлөөлж:
Чанарын Менежер албан тушаалтай
..... /З.Ариунгоо/ →
Утас: 7509-7777
РД: 6610188
Хаяг: Баянгол дүүрэг, 24-хороо, Тээвэрчдийн гудамж 85 тоот
Утас:



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



000156316

2018.03.23

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011734009

/ Хувийн хэргийн дугаар /

6289754

/ Регистрийн дугаар /

Эрдэнэс алт ресурс

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

/ шийдвэрийн нэр /

6

/ дугаар /

2018.03.13

/ он, сар, өдөр /



8299

/ код /

Бизнесийн зөвлөгөө

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

100,000.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, 15-р барилга, 15 давхарт, Утас1: 0, Утас2: ,
Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэг /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Сумъяа овогтой Эрдэнэбулган-а Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч-р томилсныг бүртгэв.	2018.03.23	Б.Лхагвасүрэн
1	Дорж овогтой Ариунболд -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.05.03	Б.Лхагвасүрэн
	2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэв.	2018.07.09	Ж.Нямдорж Г.Алтай
3	Болдбаатар овогтой Ачитсайхан -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.03.05	Г.Алтай
4	Дүрмийн 1.2, 5.1, 6.1, 7.2, 7.3.1, 7.3.5, 7.3.7, 7.3.9, 7.3.12, 7.3.13, 11.1, 11.2, - т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2022.11.28	Ш.Очирсүрэн
5	Дүрмийн 5.1 заал-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2023.01.09	Ш.Очирсүрэн
6	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2023.05.22	С.Баасандулам
7	Эрдэнэчулуун овогтой Ууганбаяр-а Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.10.18	С.Баасандулам
12	08990 Уул уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглах, олѳ орлох /2023.11.03-2049.10.17/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2023.11.06	Ш.Очирсүрэн
	09909 Гэрээгээр өрөмдлөг хийх үйл ажиллагаа шинээр бүртгэв.		
13	09900 Уул уурхайн чиглэлээр зөөлөгөө өгөх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2023.11.03	Ш.Очирсүрэн
	09901 Ашигт малтмалын хайгуул /2023.08.27-2024.08.27/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.		
14	Эрдэнэчулуун овогтой Ууганбаяр-а Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2024.11.05	Л.Хийшжаргал



... он 12 сар 16 өдөр Бүртгэлийн № 1148
 Нийслэлийн тойргийн нотариатч
 Д.Амаржаргал би энэ хуулбарын
 үнэн зөвийг гэрчлэв.
 Нотариатч





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-021483*

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг
үндэслэн

Дундговь аймаг /хот/-ийн

Гурвансайхан сум /дүүрэг/-ын

Салхит нэртэй газарт орших

2887.85 гектар талбай бүхий уурхайн талбайд
хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал
ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011734009 тоот гэрчилгээтэй

“Эрдэнэс алт ресурс” ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2049.10.17 дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.БАТМАГНАЙ

2023 оны 11 дүгээр сарын 03 ны өдөр

Улаанбаатар хот

0000702



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-021483

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2019.10.17, дуусах хугацаа 2049.10.17Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөвКадастрын хэлтсийн даргын 2019.10.14-ний 514 тоот шийдвэр	2019.10.17 АМГГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595
002-PL	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9016001019 тоот улсын бүртгэлийн дугаартай Монгол улсын хөгжлийн банканд барьцаалахКадастрын хэлтсийн даргын 2020.03.16-ны 84 тоот шийдвэр	2020-03-16 АМГГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595
004-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.10.17 – 2021.10.17 хүртэл	2021.01.07
005-CN	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэрийг 9011474118 тоот улсын бүртгэлийн дугаартай Эрдэнэс силвер ресурс ХХК болгон өөрчлөх. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн компаний оноосон нэрийг өөрчлөв.Кадастрын хэлтсийн даргын 2022.01.04-ний --- тоот шийдвэр	АМГГ 11 ОДОНГИ УУД УУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043 2022.01.20
006-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.10.17 – 2022.10.17 хүртэл	АМГГ 11 ОДОНГИ УУД УУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043 2022.01.20
007-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.10.17 – 2023.10.17 хүртэл	АМГГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043 2022.10.17



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-021483

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-CN	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэрийг 9011474118 тоот улсын бүртгэлийн дугаартай Эрдэнэс силвер ресурс ХХК болгон өөрчлөх. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн компаний оноосон нэрийг өөрчлөв.Кадастрын хэлтсийн даргын 2023.08.01-ний --- тоот шийдвэр	<div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</div> <p style="text-align: right;">2023.09.18</p>
009-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.10.17 – 2024.10.17 хүртэл	<div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</div> <p style="text-align: right;">2023.09.18</p>
010-TF	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9011734009 тоот улсын бүртгэлийн дугаартай Эрдэнэс алт ресурс ХХК-д шилжүүлэхКадастрын хэлтсийн даргын 2023.11.03-ний 373 тоот шийдвэр	<div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">4 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</div> <p style="text-align: right;">2023.11.03</p>
012-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.10.17 – 2025.10.17 хүртэл	<div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</div> <p style="text-align: right;">2024.08.05</p>



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-021483

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	• Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2019.10.17	2887.85 Га	0 Га	1	107° 0' 1.48"	45° 51' 57.68"
				2	107° 0' 1.48"	45° 51' 54"
				3	107° 1' 26"	45° 51' 54"
				4	107° 1' 26"	45° 51' 0"
				5	107° 0' 1.48"	45° 51' 0"
				6	107° 0' 1.48"	45° 48' 43.64"
				7	106° 57' 22.8"	45° 47' 53.22"
				8	106° 57' 21.24"	45° 47' 47.95"
				9	106° 56' 0.03"	45° 47' 48.01"
				10	106° 56' 0.04"	45° 49' 24.45"
				11	106° 59' 29.92"	45° 49' 24.51"
				12	106° 59' 29.92"	45° 50' 47.52"
				13	106° 55' 49.09"	45° 50' 47.56"
				14	106° 55' 49.09"	45° 51' 57.68"

КАДАСТРЫН ХӨЛӨӨ
2019.10.17-ийн БҮРТГЭЭ Д.Мягмарсүрэн
УХА0595



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 1/218

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Т/21-15-12 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг хүлээн авсанд тооцсугай.
2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.
3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.
4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.
5. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивт, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг Эрдэнэс Силвер Ресурс ХХК -д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2021 оны 10 дугаар сарын 29

№ Т/21-15-12

Улаанбаатар хот

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг хэлэлцсэн тухай

"Эрдэнэс Силвер Ресурс" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Дата ресурс" ХХК боловсруулсан Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-д Монгол Улсын уул уурхайн зөвлөх инженер Т.Батбаяр зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер С.Цэдэндорж, Монгол улсын зөвлөх инженер Б.Чинзориг нар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэл тодотгол 1-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1 нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1 нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник-эдийн засгийн үндэслэл тодотгол 1 нь төслийн танилцуулга, төслийн талбайн ерөнхий мэдээлэл, геологийн судалгааны түүх, геологийн тогтоц, ил уурхайн төлөвлөлт, баяжуулах технологи, дэд бүтэц, хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, зах зээлийн судалгаа, төслийн эдийн засаг 11 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 252 хуудас тайлбар бичиг, 17 хавсралт зургуудаас бүрдэж байна.
4. "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордын MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн ХХ-01-06 тоот дүгнэлтийг гаргасан ҮГА-ны даргын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Н/46 тоот тушаалаар мөнгө, алтны нөөцийг бодитой (В) зэрэглэлээр


12. Салхитын мөнгө-алтны ордыг ашиглах 5 жилийн хугацаанд ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 43,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс 4,733.8 сая.төгрөг барилга байгууламж, 22,120.3 сая.төгрөг баяжуулах үйлдвэр, 5,777.3 машин, тоног төхөөрөмж, 10,883.9 сая төгрөгийн бусад зардлууд тут тус эзэлж байна. Төсөл хэрэгжүүлэгчийн одоо ашиглаж буй хөрөнгийн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар үлдэгдэл өртөг нь нийтдээ 43.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ 86.6 тэрбум төгрөг байна..

13. Уурхайг ашиглах төслийн 5 жилийн хугацаанд нийт 1,041.04 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 366.15 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 610.8 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 462.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 495.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улсын төсөвт 206.92 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Үйлдвэрлэлийн бүрэн өөрийн өртөг нь 53,450.4 төг/тн байна.

14. Хорогдуулалтын нормыг жилийн 10 хувиар тооцоход төслийн өнөөгийн үнэ цэнэ (NPV, @10%) 287.85 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 110.4 хувь байна. Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1 жил байхаар тооцсон байна.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар баталсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг ЭБМЗ-өөс анхааруулж байна.
1. Төсөл хэрэгжүүлэгч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу ашиглалтын үйл ажиллагааг явуулж, олборлосон алтаа Монгол улсын төв банк Монгол банкинд "Эрдэнэс Силвер Ресурс" ХХК-ийн нэр дээр тушааж байхыг анхааруулж байна.
2. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
3. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
4. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.
5. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Дата Ресурс" ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан Монгол Улсын уул уурхайн зөвлөх инженер С.Цэдэндорж, Монгол Улсын уул уурхайн зөвлөх инженер Б.Чинзориг нарын шинжээчид тус тус хариуцна.



Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов.

Үүнд:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ



АЖИЛ ОЛГОГЧИЙН ХАРИУЦЛАГА, ГЭНЭТИЙН ОСЛЫН БАГЦ
ДААТГАЛЫН ГЭРЭЭ

“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ийн **ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:**
Та бүхэнд энэхүү гэрээтэй холбоотой аливаа тодруулга, асуулт байвал тус гэрээг
Хариуцсан дараах ажилтанд хандана уу:


О.Тогосмаа
Байгууллагын даатгалын менежер
Утас: (+976)-8810-0573
Цахим хая: togosmaa@munkhdaatgal.mn


ГЭРЭЭНИЙ ДУГААР:

№:D24438028

Хэрэв та бүхэн нөхөн төлбөртэй холбоотой асуудлаар холбогдохыг хүсвэл
дараах утсаар холбогдоно уу:

Нөхөн төлбөрийн алба
24 Цагийн нэгдсэн шуурхай албаны утас: (+976)-7599-1100
Э-Шуудан: nuhuntulbur@munkhdaatgal.mn

 (+976)-75991100

 info@munkhdaatgal.mn

 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн
ерген чөлөө, Мөнх Тауэр, 10-р давхар

БАТЛАВ:



““ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК



